



Монгол Улсын Их Хурлын Дарга

Ноён З.Энхболд ТАНАА

**“ТӨГС ТӨГӨЛДӨРШИЛ”  
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,  
2-р Дочин мянгат, 21-р байр, 16 тоот,  
шуудангийн салбар-44, шуудангийн хайрцаг-868  
Утас: 96009132

2014 - 06 - 25 № \_\_\_\_\_

Төгс Төгөлдөршил Төрийн бус байгууллага нь Монгол Улсын төрт ёс, төрийн түүх, төрийн байгуулалт, хууль ёс, Үндсэн хууль, монголчуудын эрх, эрх чөлөөний асуудлаар зохих судалгаа шинжилгээ, мониторингийн ажлуудыг гүйцэтгэдэг бөгөөд гүйцэтгэсэн зарим нэг ажлын үр дүнгээс Танд танилцуулж байна. Энэ ялдамд Танд ажлын их амжилт хүсэн ерөөе. Таныг гүнээ хүндэтгэсэн



Төгс Төгөлдөршил ТББ-ын Тэргүүн

*Д. Орхон* Д.Орхон

## БОГД ХААНТ НЭГДСЭН МОНГОЛ УЛСЫГ ЗАДЛАЖ, УСТГАСАН ҮНЭН ТҮҮХ

### Өмнөтгөл үг

Аливаа улс орны түүхэнд тухайн улсын байр суурийг олон улсын харилцаанд тодорхойлсон хоёр болон олон талын гэрээнүүд байдаг. Богд хаант нэгдсэн Монгол Улсын олон улсын харилцаанд эзлэх байр суурийг 1912 оны Орос-Монголын гэрээ, худалдааны протокол, 1913 оны Орос-Хятадын тунхаг, ноот, 1915 оны гурван улсын Хиагтын гэрээ гэсэн цуврал гэрээ бичгүүдээр тодорхойлсон юм.

Монголын төрт улс сэргэн мандаж, Богд хаант нэгдсэн Монгол Улсыг зарлан тунхагласанаас үүдэн Монголын талаархи 1912, 1913, 1915 оны гэрээнүүд байгуулагдсан нь гэрээнүүдийн хууль зүйн талыг хөндөж тавихын учир шалтгааны эх үндэс болох юм.

### 1911 он. Богд хаант нэгдсэн Монгол Улс байгуулагдсан нь

Монголчууд Манж Чин улсын 200 гаруй жилийн ноёрхолыг түлхэн унагаж, 1911 онд Богд хаант нэгдсэн Монгол Улсыг байгуулсан. 1911 оны буюу цагагчин гахай жилийн өвлийн тэргүүн сарын арван нэгэнд тараасан “Монгол, орос, төвд, иргэн, шар, хар, олон хүнд нийтээр ухуулан зарлах бичиг”-т “...манай Монгол болбаас угтаан тусгай нэгэн улс мөн тул одоо хуучин журмаар өвсөвөөн улс болон өөрийнхүү хэргийн эрхээ бусдаар эрхлүүлэхгүй...” гэж заасан нь Богд хаант нэгдсэн Монгол Улс нь Төв Азийн элгэн дэх өргөн уудам нутагт урьд, нэн эртнээс оршин байсан Хүннү, Их монгол зэрэг гүрэн улсуудын залгамж мөн болохыг тодорхойлсон төдийгүй урьдын бүх журмаа баримтлан улс болон төвхнөж, тусгаар тогтносон бүрэн эрхтэй улс гэдгээ зарлан тунхагласан юм. Энэ бол Богд хаант нэгдсэн Монгол Улс, эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олсон монголчуудын хууль ёсны хүсэл зориг мөн.

Оросын монгол судлаач Ю.Кушелев монголчууд тусгаар тогтнолоо зарласныг бичихдээ: “...монголчуудын туслалцаатайгаар Тэнгэрийн гүрнийг байгуулсан Дайцинууд /манж нар-зохиогч/өөрсдөө хятадуудад боолчлогдсоноор Монголыг эзэрхэх эрхээ алдаж байгаа юм. Дайцинуудын хаанчлал нь ... мөхөсдөж, хүчин суларснаас үүдэн монголчууд өөрийн тусгаар тогтнолыг зарлах эрхгүй юм гэж үү” хэмээн асуугаад “Монголыг тунхаглах тэр мөчид Хятадад үндсэндээ хууль ёсны төр улс байхгүй байсан” гэж 1912 онд хэвлүүлсэн бүтээлдээ дурдсан байдаг. Английн эрдэмтэн Д.Каррутэрс манжууд “...хаан суудлаас түлхэгдсэн учир монголчуудын хувьд Хятад дахь шинэ дэглэмд захирагдах зайлшгүй шаардлага... үгүй болж байгаа юм” гэж бичсэн зэргээс үзэхэд монголчууд тусгаар тогтнолоо зарлаж, төрт улсаа байгуулах нь тэдний хэрэг бөгөөд тийм ч учраас Богд хаант нэгдсэн Монгол Улс байгуулагдсаныг түүхийн хувьд зайлшгүй болохыг эдгээр эрдэмтэд, судлаачид хүлээн зөвшөөрч, нотолж байна.



Гарал үүсэл, хэл соёл, хэв заншил, газар нутаг, түүх нэгтэй монголчууд өөрийн дотоод хэргийг өөрсдөө, хөндлөнгийн оролцоогүйгээр шийдвэрлэж, гадаадад явуулах бодлогоо тодорхойлох нь тэдний зүй ёсны эрмэлзэл, хууль ёсны эрх мөн. Монгол судлаач Владимир Котвич 1914 онд хэвлүүлсэн номондоо: "Одоо монголчууд умарт тийш Аригун мөрөн, Байгаль нуур, Тагна уул, өмнөд зүг хятадын их хэрэм, Түвдийн өндөрлөг тулсан асар удам нутгийг эзэмшиж байна" хэмээн бичжээ. 1911 оны 12 дугаар сарын эцсээр Монголын хаан ширээнд суусан 8-р Жибзундамба хутагт нь Богд хаан цолтойгоор төрийн дээд эрхийг барихаар олноо өргөгдөж, Дотоод, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх яамнаас бүрэлдсэн Засгийн газрыг байгуулж, Богд хаант нэгдсэн Монгол Улсын засаглах эрхийг барьсан нь монголчууд өөрийн төр, засгийн газартай болсон хэрэг байв. Богд хаант нэгдсэн Монгол Улсад дагаар орж нэгдэхийг хүссэн монгол туургатнууд халх дөрвөн аймгаас гадна бүх шавь, өвөрмонголын Шилийн гол, Улаан цав, Их зуу, Зост, Зуу од, Жирмийн зургаан чуулган, Дөрвөдийн хоёр аймаг, торгууд, хошуудын 3 хошуу, Тагна урианхайн 5 хошуу, Хөвсгөл нуурын урианхай хошуу, урагшаа Хөх хотын Түмэдийн хоёр хошуу, Хөлөнбуйрын баргын 10 хошуу, Цахар 8 хошуу, даригангын 5 гар хошуу, жич, Хөх нуур, ар Илийн хошууд, торгууд, өөлд, цахар хэд хэдэн хошууд цөм Монгол улсын харьяат болж, захирагдан дагаар орсон бөгөөд дагаар орсон нь тэдний сайн дурын хэрэг, зуун зуун жилийн харийн дарангуйлалаас чөлөөлөгдөн өөрийн нутагт эрх чөлөөтэй амьдрах гэсэн олон монголчуудын бүгдийн хүсэл зориг байсан. Ийнхүү Богд хаант нэгдсэн Монгол Улс нь засгийн газартай, хүн амтай, нутаг дэвсгэртэй, улс төрийн хувьд нэгдмэл нэг удирдлагатай хууль ёсны төрт улс болон бүрэлдэж тогтсон юм.

Богд хаант нэгдсэн Монгол Улс нь байгуулагдсан цагаасаа монголчуудын үндэсний эрх чөлөөний хувьсгалын ялалтыг орос, хятадуудад төдийгүй бусад улс орнуудын удирдагч нарт ойлгуулах, төрт улсаа олон улсын эрх зүйн дагуу баталгаажуулах, тусгаар тогтнолоо дэлхий нийтэд хүлээн зөвшөөрүүлэх байр суурийг байнга илэрхийлж, эрчимтэй арга хэмжээ авч байсан.

### 1911 он. Хаант Оросын байр суурь

Арвандолдугаар зуунаас хойш 200-300-аад жилийн турш оршин байсан Манж Чин гүрэн 1911 онд задран унаж, түүний туурин дээр Богд хаант нэгдсэн Монгол Улс, Думдад иргэн улс буюу Хятадын хөрөнгөтний улс, Түвдийн тусгаар тогтносон улс гэсэн гурван туурга тусгаар улс сэргэн мандсан нь хорьдугаар зууны эхэн үед Төв Азид тогтсон байсан статус-кво байдлыг алдагдуулж, тухайн үеийн дэлхийн тэргүүлэгч улс орнуудын хүчний харьцаанд өөрчлөлт оруулсан юм. Бий болсон байдлыг аль болох өөртөө ашигтай болгох бодлогыг Хаант Орос улс баримталж байсан. Ялангуяа, түүнтэй хил залгаа орших нутагт Богд хаант нэгдсэн Монгол Улс байгуулагдсан нь Хаант Орос улсын хувьд нэн түгшүүртэй байсантай холбоотой.

Хаант Орос нь нэгдүгээрт, алдагдсан статус-кво байдлыг сэргээх, тэгэхдээ, хоёрдугаарт, бий болсон байдлыг өөртөө хожоотой ашиглаж, задран унасан Манж Чин улсын туурин дээр шинээр байгуулагдсан Хятадын бүгд найрамдах хөрөнгөтний улсаас мөн шинээр байгуулагдсан Богд хаант нэгдсэн Монгол Улсыг бүрэлдэхүүндээ оруулах гэсэн санаархлыг нь мохоох, гуравдугаарт, Богд хаант нэгдсэн Монгол Улсыг хүчирхэгжүүлэлгүй, тусгаар тогтнолыг нь эвдэж, яваандаа өөртөө нэгтгэх гэсэн бодлоготой байв. Энэ гуравдугаарт



дурдсан зүйл нь Богд хаант нэгдсэн Монгол Улсын талаар Хаант Оросын явуулсан бодлогын үндэс суурь нь байлаа. Учир нь Богд хаант нэгдсэн Монгол Улс хүчирхэгжин бэхжсэний дараа Хаант Орос болон задран нурж, дэлхийн улс төрийн тавцангаас арчигдан алга болсон Манж Чин улсын хооронд арвандолдугаар зуунаас хойш цувралаар байгуулсан гэрээнүүдээр тогтоосон хилийн цэсийг хүчингүйд тооцуулах, монголчуудын гарал үүсэлтэй холбоотой, нэн эртнээс өвөг дээдсийн үеэс амьдран нутаглаж, эзэмшиж ирсэн Байгал далай, хойд нутгийнхаа асуудлыг гарцаагүй тавьж магадгүй байсан тул Хаант Орос улс өөрт нь тааламжгүй үр дагавартай үйл явдлын өрнөлөөс өрсөн, өөрийн хүсэл зоригийг Богд хаант нэгдсэн Монгол Улсад тулган хүлээлгэх гэж их хичээсэн нь Монголын талаархи бодлогоо хэрэгжүүлэхэд Хаант Орос улс идэвхтэй байсаны тайлбар юм.

Түүхийн баримтаас шүүхэд, Хаант Орос улс нь монголчуудын нэгдсэн улс байгуулагдсаныг хүлээн зөвшөөрөхгүй байх бодлого анхнаасаа баримталсан нь Богд хаант нэгдсэн Монгол Улс байгуулагдсантай үүдэн өрнөсөн дипломат харилцааны бүр эхэн үеэс илрэн гарчээ. Хаант Оросын Гадаад явдлын яамны сайд Сазановоос Монголын Засгийн Газартай хэлэлцээр хийх бүрэн эрхт төлөөлөгч Коростовецид 1912 оны 8 дугаар сарын 23-нд явуулсан захидалд: “манай хязгаартай хил дэрлэх энэ мужид цэргийн хүчтэй улс байгуулахгүй байхыг эрмэлзэх” нь Халхад явуулах улс төрийн бодлого мөн гэснээс үзэхэд Хаант Орос улс нь нэгдүгээрт, Богд хааны удирдлаган дор Монголын нэгдсэн улс байгуулагдсаныг үгүйсгэж, монголчуудын нутаг дэвсгэрийг Халхаар хязгаарлах, хоёрдугаарт, Монгол орныг хуваагаад түүний төв хэсэг болох Халхыг хятадад өгөхгүй байх, гуравдугаарт, Монгол улсыг хүчирхэгжэхээс болгоомжилж, цэргийн хүчтэй улс болгохгүй байх гэсэн зорилготой байжээ. Ийнхүү Хаант Орос улс Богд хаант нэгдсэн Монгол Улс байгуулагдаж, Монгол улс сэргэн мандсаныг үгүйсгэж, монголчуудын эрх чөлөөтэй амьдрал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийг Халхаар хязгаарлах, монголчуудыг нийгэм-эдийн засгийн хувьд бэхэжсэн төрт улстай, хүчирхэг цэрэг арми бүхий улс болгохгүй байлгах бодлого баримталсан нь монголчуудын түүхэнд шууд нөлөөлж, 1911 оны болон 1921 оны, мөн 1990 оны хувьсгалын өрнөлийг сааруулан зогсоох түүхэн урьдчилсан угтвар суурь нөхцөлийг бүрэлдүүлж, олон арван жил, одоо хүртэл үргэлжилсээр байгаа, цаашид ч гэсэн үргэлжилсээр байх магадлалтай, үндэсний үзэлтэй /үндэсэрхэг үзэлтэй биш юм шүү, хольж хутгаж ойлгож болохгүй/, монголоо гэсэн сэтгэлтэй мянга мянган монголчуудыг хэлмэгдүүлэх хэлмэгдүүлэлтийн улс төр-геополитикийн үндсийг тавьсан.

Монголын талаар Хаант Оросын Засгийн газрын бодлогыг илэрхийлсэн уг захидалд, монголчуудын тэмцэж олсон эрх чөлөө, тусгаар тогтнолыг үгүйсгэж, Богд хаант нэгдсэн Монгол Улсын бүрэн эрхийг автономит болгох зорилт дэвшүүлжээ. Хаант Оросын сайд Сазанов бичихдээ: “үүгээрээ бид Монголыг хэлэлцэгч тал болохыг хүлээж, түүнийг автономит болохыг зөвшөөрөв” гэсэн нь олон улсын гэрээ эрхийн тэгш эрхт субъект, тусгаар тогтносон улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс хутгалдан оролцсон явдал юм. Ингэхийг Богд хаант нэгдсэн Монгол Улсын Засгийн газар эсэргүүцэж, Хаант Оросын Засгийн газарт мэдэгдэж байсаныг Монголын талтай хэлэлцээр хийх бүрэн эрхт төлөөлөгч Коростевец Засгийн газартаа явуулсан утсандаа мэдэгдсэн байдаг. 1912 оны 9 дүгээр сарын 27-нд явуулсан Коростевецийн цахилгаан утсанд: “Монголын Засгийн газар ... өөрийн тусгаар тогтнолыг Хятад төдийгүй ер нь аль ч улс, гүрнээс үл хамаарах...” болохыг мэдэгдэж байсныг дурджээ.



### 1911 он. Хөрөнгөтний Хятад улс буюу Думдад Иргэн улсын байр суурь

Хятадын тал Богд хаант нэгдсэн Монгол Улсыг тунхагласан цаг мөчөөс түүнийг хүлээн зөвшөөрүүлэхгүй байхын төлөө чармайн тэмцэж, монголчуудын түүх, Манж Чин улсын дарангуйлалыг эсэргүүцэн тэмцсэн монгол ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүхийг мушгин гуйвуулж, тэдний төр улсаа байгуулах, нийгмийн байгуулал, хөгжлийн замаа сонгох, улс үндэс, газар нутгаа нэгтгэх, хэв заншил, хэл, соёл, бичиг үсгээ хадгалах, уламжлуулах, дэлгэрүүлэх гэсэн хууль ёсны эрмэлзлэлийг аль болохоор үгүйсгэх гэж оролдож байсан юм. Юань Шикайгаас монголын шашин төрийг хослон баригч Богд хаанд 1912 онд илгээсэн цахилгаан утас болон Богд хаанаас түүнд явуулсан хариу зэргээс үзэхэд, Юань шикай Монгол нь Хятадын бүрэлдэхүүн учир түүнийг тусгаар тогтносон гэж хүлээн зөвшөөрөхгүй, харин Богд тэргүүтэй монголын ноёд дуулгавартай байвал их шан харамж, зэрэг дэв өгнө гэх мэтээр монголын талаар баримтлах бодлогоо тодорхойлсныг Богд хаан эсэргүүцэж, монголчууд Манж Чин улсад дагаар орсон болохоос Хятадын бүрэлдэхүүнд байгаагүй, иймд Хятадын талын санаархлыг зөвшөөрөхгүй гэсэн утга бүхий хариу өгчээ. Монголчууд эртний журмаа баримтлан өөрсдийн байгуулсан төрт улс, тусгаар тогтнолоо, нэгдсэн улсаа хүлээн зөвшөөрүүлэх бодлоготой байсан нь хэнд ч ойлгомжтой билээ.

### 1912 он.Орос-Монголын гэрээ

Монголын талаархи гэрээнүүдэд оролцогч талуудын хүсэл зориг ийнхүү хурц зөрчилтэй байсан нөхцөлд Орос, Монгол хоёр 1912 оны гэрээ, протоколыг байгуулсан нь монголчуудад нэг шат ахисан сайшаалтай хэрэг байсан боловч монголчуудын хувьд даанч их санасан газар есөн шөнө хоосон хонов гэдэг шиг зүйл болж, Хаант Орос улс монголчуудыг хуурч мэхлэн, эрх тэгш бус, дээрэнгүй нөхцөл байдлыг монголчуудад тулгасан билээ. Гэрээний нэгдүгээр зүйлээр, Монголд автономит тогтоохоор зааж, хоёрдугаар зүйлд нь Монголд оросын худалдаачдын эдлэх эрх ямбыг монголын тал хангах, хамгаалах үүрэгтэй болох тухай заасан байдаг бол гуравдугаар зүйлд нь Монгол улс Хятад болон өөр бусад оронтой гэрээ хэлэлцээр хийх бүрэн эрхтэй болохыг хоёр тал харилцан зөвшөөрөлцсөн санаа тусгагджээ. Гэрээнд Богд хаант нэгдсэн Монгол Улсыг автономит Монгол улс хэмээн нэрлэж, түүний хил хязгаарыг тодорхойлоогүй байна. 1912 оны Орос-Монголын гэрээ, протокол нь нэгдүгээрт, Богд хаант нэгдсэн Монгол Улсын тусгаар тогтносон байдлыг автономит болгосон, хоёрдугаарт, талуудын хүлээсэн үүрэг тэнцвэргүй, эрх тэгш бус болсон шинжүүдийг агуулж байгаагаараа хууль бус билээ. Энэ гэрээнд Монголын талын тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэх гэсэн хүсэл зориг тусгагдаагүй, харин ч Богд хаант нэгдсэн Монгол Улс статусын хувьд 1911 оноос дордож, тусгаар тогтносон улс гэсэн статустай байсан Богд хаант нэгдсэн Монгол Улс маань автономит Монгол Улс болон зиндаа доошилсон юм. Ийнхүү 1912 онд Хаант Орос улс, Богд хаант нэгдсэн Монгол Улсын хооронд гэрээ байгуулагдаж, Монголд нөлөөлөх Оросын байр суурийг бэхжүүлсэн нь Орос, Хятадын харилцаанд өөрчлөлт оруулж, тэдний зүгээс Монголын асуудлаар баримтлах бодлогоо зохицуулах, нэгдсэн үзэл боловсруулахад хүргэжээ. Тэгээд ч оросууд устаж алга болсон манж нарын оронд Азид байх ашиг сонирхлынхоо хүрээнд монголчуудыг биш, хятадуудыг татан оролцуулахаар сонголтоо хийж, Азийн олон улс орнуудаас хятадыг ийнхүү Орос улсын гол харилцагч болгосноор монголчуудыг өөрийнхөө үндсэн ашиг сонирхлын хүрээний гадна хаясан билээ. Оросууд нэгэнт хятадыг өөрийн гол харилцагч гэж тодорхойлж, сонголтоо



хийсэн тул Богд хаант нэгдсэн Монгол Улсын талаар хятадтай эрх ашгаа тохиролцоо шаардлагаар 1913 онд хэлэлцээр явуулж, тунхаг баталж, ноот бичиг солилцсон.

### 1913 он.Орос-Хятадын Монголын талаархи тунхаг, ноот бичиг

1913 оны 10 дугаар сарын 23-нд Орос, Хятад хамтран Монголын талаар тунхаг батлан, ноот солилцжээ. Олон улсын гэрээ эрхийн тэгш эрхт субъект болох Богд хаант нэгдсэн Монгол Улсыг үл ойшоож, тусгаар тогтносон улсын бүрэн эрхийг үл хүндэтгэн, тодорхой улсын эрх ашгийг хөндсөн асуудлаар тухайн улсыг оролцуулдаг олон улсын ёс журмыг Хаант Орос болон Хятадын хөрөнгөтний бүгд найрамдах улс хоёр огоорч Монголын талаар гэрээ байгуулсан нь олон улсын эрхийн хэм хэмжээг зөрчсөн хэрэг юм. Монголын ар хударгаар Орос, Хятад хоёр улс нууцаар хэлэлцээ хийж, Монголын асуудал гэгчийг харилцан шийдвэрлэх гэж буйг Монголын Засгийн газар бүр 1913 оны 7 дугаар сард мэдэж, мөн сарын 26-ны өдөр Оросын Засгийн газарт эсэргүүцэл илэрхийлсэн билээ. Уул бичигт:”энэ жил зуны тэргүүн сард танай засгийн хэрэг шийтгэх газраас эрхэм улс, дундад иргэн улс лугаа манай Монгол улсын хэргийг хэлэлцэн, басхүү гэрээ бичиг байгуулах хэмээж буй хэмээн сонсдох нь хэрэв үнэн болохул, Монгол улсын Засгийн хэрэг шийтгэх газарлугаа зөвлөлдөхгүй, шууд хэлэлцэх нь цаазыг тэрслүүлэхийн дээр, хэрхэн тогтох боловч манай улс хэрхэвч бээр хүлээж чадах үгүй” хэмээн заасан байна.

Тунхагийн нэгдүгээр зүйлд:”Гадаад Монгол нь Хятадын сюзеренитет болохыг Орос зөвшөөрөв” гэсэн нь үндсэндээ Богд хаант нэгдсэн Монгол Улсын хувь заяаг Орос, Хятад хоёр шийдвэрлэж, тусгаар тогтнолыг нь үгүйсгэж, түүний олон улсын харилцаанд оролцох, эзлэх байр суурийг тодорхойлжээ. “Гадаад Монгол” хэмээх нэрийн дор Орос, Хятад хоёр Халхыг өгүүлж байсан төдийгүй монголчуудын хууль ёсны төрт улсын нэрийг хэрэглээгүй нь Хаант Орос, Думдад иргэн улс хоёрын их гүрний дээрэнгүй үзлийг илтгэж байгаа юм. Ингэснээр Орос, Хятад хоёр улс нэгдүгээрт, монголчуудын хууль ёсны төрт улсыг үгүйсгэж, няцаасан, хоёрдугаарт, Богд хаант нэгдсэн Монгол Улсыг Хятадын сюзеринетет болохыг зөвшөөрч, хоорондоо харилцаагаа сайжруулсан, гуравдугаарт, Богд хаант нэгдсэн Монгол Улсыг бэхжүүлэхгүй, задлан салгаж, Халхаар нутаг дэвсгэрийг нь хязгаарлах гэсэн Оросын бодлого гүйцэлдсэн зэрэг олон зорилгыг хангасан юм. Монголын талаархи гэрээнүүдийг байгуулахтай холбоотой дипломат харилцааны эх сурвалжуудыг нягтлахад, монголчуудын эрх чөлөөний тэмцлийн үр дүнд үүссэн хууль ёсны Засгийн газартай төрт улсыг хэрхэн нэрлэхэд уг харилцаанд оролцогч талууд их анхаарч, Монголын тал “Монгол улс” гэх, Хятад анхандаа “Өргөөний Засгийн газар”, сүүлд нь “Гадаад Монгол” гэх, Хаант Орос нь Монгол улстай байгуулсан 1912 оны гэрээ, протоколд “Монгол улс”, 1913 онд Хятадтай хамтран гаргасан тунхагт “Гадаад Монгол” хэмээн нэрлэсэн нь 1915 оны Хиагтын гэрээнд тусгагджээ. Энэ бол олон улсын эрхийн актанд бичигдэх нэрийн төлөө төдий тэмцэл биш, Монголын ард түмний эрх чөлөөт амьдрал, монгол үндэстний ирээдүй, тэдний олон мянган жилээр амьдран ирсэн, амьдарсаар байгаа газар нутгийн төлөө улс төрийн далд агуулгатай тэмцэл байв. Хорьдугаар зууны эхний арван жилд Монголд өрнөсөн тэмцэлийг Хаант Оросын нэгэн хэвлэлд:”Монголын уудам талд нүүдэлчдийн дунд Хятад, Оросын улс төрийн нөлөөний тэмцэл, эзэнт гүрэн, бүгд найрамдах, шашин төрийг хосолсон хаант засгийн төлөө үзэл санааны тэмцэл, “Монгол улс монголчуудад”, “Монгол улс хятадуудад” гэсэн үзэл бодлын тэмцэл өнөө явагдаж байна” гэж бичжээ.



Тунхагийн хоёрдугаар зүйлд: “Хятад улс Гадаад Монголын автономитыг зөвшөөрөв” гэсэн нь тунхагийн нэгдүгээр зүйлийг тодотгож, Халхыг хятадад өгөлгүй өөрөө засан тохинох эрхтэй гэсэн Хаант Оросын улс төрийн бодлогыг илэрхийлсэн санаа юм. Нэг, хоёрдугаар зүйлүүдэд заасанаас харахад, Богд хаант нэгдсэн Монгол Улсыг задлах, нэг хэсгийг нь “Гадаад Монгол” гэж нэрлэж, ийнхүү нэрлэсэн тэр хэсгийг Оросын протекторатын дор автономит байлгах гэсэн санаанууд тодорхой байна. Ер нь 1913 оны тунхаг нь Богд хаант нэгдсэн Монгол Улсыг задлан хуваагаад, Хаант Орос, Хятад хоёр тус тусад нь захирах гэсэн улс төрийн бодлогыг тусгажээ.

Тунхагийн гуравдугаар зүйлд, Хятад улс Халхад цэрэг оруулахгүй, Халхыг хятадчилахгүй гэсэн үүрэг авч, Орос мөн өөрийн зүгээс Халхыг оросчлохгүй, цэргээ тэнд байлгахгүй гэсэн үүрэг харилцан хүлээжээ. Хятад, Хаант Оросын ийм байр суурь Халхыг хэн хэндээ өгөлгүй, болж өгвөл өөр өөрийн эзэгнэлд оруулж, нутаг дэвсгэрийг нь хураах гэсэн бодлогуудын сөргөлдөөний үр дүн бөгөөд үүнтэй уялдуулан монголчууд Халхад өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх онцгой эрхтэй гэсэн заалтыг арга буюу нэг гол санаа болгон оруулсан байна.

Тунхагийн дөрөвдүгээр зүйлд Хятад улс ийнхүү тунхагийн нэг, хоёр, гуравдугаар зүйлүүдэд тусгасан үндсэн зарчмуудыг баримтлахыг хоёр талын үүрэг болгохыг зөвшөөрсний дагуу Гадаад монголтой /Халхтай/ харилцаа тогтооно гээд 1912 оны Орос-Монголын гэрээ, протоколын гэрээг дурдалгүй, протоколыг нь мөрдөх болно гэсэн санаа бүхий заалт оруулсан байна. Тэр эрхийн онолоор бол тусгаар тогтносон улс орны бүрэн эрхэд газар нутаг, хүн ам, засаглах эрхээс гадна олон улсын харилцаанд чөлөөтэй оролцох, аль ч асуудлаар ямар ч улс оронтой гэрээ хэлэлцээр байгуулах эрх багтдаг. 1912 оны гэрээгээр Богд хаант нэгдсэн Монгол Улс нь олон улсын харилцаанд оролцож, гэрээ байгуулж болох тухай заасан байдаг нь хятадуудад таашаагдаагүй байна. Иймд хятадууд 1913 оны тунхагт 1912 оны Орос-Монголын гэрээг дурдахгүй байх талаар Хаант Оросод шахалт үзүүлж, зөвхөн протоколыг мөрдөх тухай санаа оруулжээ. Ингэж Монгол орон, монголчуудыг ертөнцөөс тусгаарлах гэсэн бодлогоо хоёр улс хууль зүйлийн шинжтэй болгож, хоёр улсын хоорондын хэлэлцээрт тусгаж, бататгасан байна. Өөрөөр хэлбэл, Манж Чин гүрний үед манжууд монголчуудыг хорвоо ертөнцөөс тусгаарлаж, дэлхийн олон улс оронтой чөлөөтэй харилцах эрхийг нь боомилж, монголчуудыг хөмөрсөн тогоон дотор байлгах бодлого хэрэгжүүлж байсаныг Хаант Орос, Хятад хоёр дахин амьдралд хэрэгжүүлэхээр 1913 онд хамтарсан тунхаг баталж, ноот бичиг солилцсоноор монголчуудыг мөхөөх, монголчуудыг мохоох гэсэн гутамшигтай түүх давтагдсан байна.

Тунхагийн тавдугаар зүйлд, Гадаад Монголын талаархи Орос, Хятадын эрх ашгийг хөндсөн асуудлыг тусгай гэрээ хэлэлцээрээр шийдвэрлэх болно гэжээ. Өгүүлсэн бүгдээс үзэхэд, монголчуудын тусгаар тогтнол, хууль ёсны эрх ашгийг үгүйсгэсэн 1913 оны Орос-хятадын тунхаг нь 1912 оны Орос-Монголын гэрээнээс утга санааны болон үр дагаварын хувьд монголчуудад илүү сөрөг, илүү харгис шинжтэй болж, Богд хаант нэгдсэн Монгол Улсын бүрэн эрхийг хязгаарлаж, олон улсын харилцаанд чөлөөтэй, бие даан оролцох эрхийг нь хассан байна. 1912, 1913 оны гэрээ бичгүүдэд Богд хаант нэгдсэн Монгол Улсын хилийн цэсийн талаар шууд заагаагүй боловч Хаант Орос, Хятадын солилцсон ноот бичгийн дөрөвт, Халх, Улиастай, Ховдод сууж байсан манжийн түшмэдүүдийн захиргаанд өгсөн газрууд



бөгөөд Хятад улстай нийлсэн хил бол зүүн зүг Хөлөнбуйр, өмнө зүг Шинэ хязгаар, баруун зүг Алтайн хязгаар лугаа зах нийлсэн Халхын дөрвөн аймаг ба Ховдын хязгаарын олон хошуудын хилээр болохыг тодорхойлсон байдаг нь монголчуудын өнө эртнээс амьдарч ирсэн, амьдарсаар байгаа газар нутгийг задлан хувааж, гарал угсгаа, хэл заншил, соёл түүх нэгтэй ард түмнийг хэсэглэн салгахад чиглэсэн явууллага байсан байна. Монголчуудын эв нэгдлийг бусниулж, түүний хууль ёсны эрх ашгийг огоорч, дотоод хэрэгт нь хутгалдан орсон энэ явууллага нь олон улсын хэм хэмжээ зөрчсөн хууль бус үйл ажиллагаа юм. 1913 оны Орос-хятадын тунхаг нь өөр хоорондын асуудлаар Орос, Хятад улс бодлогоо зохицуулсан хэрэг биш, харин олон улсын харилцааны тэгш эрхт субъект болох Богд хаант нэгдсэн Монгол Улсын хүсэл зоригийг үл хайхарч, бүрэн эрхийн зөрчиж байгуулсан хууль бус гэрээ эрхийн акт юм.

### 1915 он. Хиaгтын гэрээ

Орос, Хятад улс 1913 оны тунхаг, ноотод тусгаж тохиролцсон хамтын бодлогоо хэрэгжүүлэхийн тулд Богд хаант нэгдсэн Монгол Улсын төр, засгийн газарт тулган хүлээлгэж зөвшөөрүүлэх шаардлагатай болсон билээ. Үүнтэй уялдан Орос, хятад, Богд хаант нэгдсэн Монгол Улсын хооронд дипломат ажиллагаа идэвхитэй явагдаж, түүний үр дүн нь 1915 оны Хиaгтын гурван улсын гэрээ болсон юм.

Хиaгтын гэрээний нэгдүгээр зүйлээр, Монголын тал 1913 оны Орос-хятадын тунхаг, ноотыг хүлээн зөвшөөрсөн нь Орос, хятадын хамтын шахалтанд хүчин мөхөсдөж, илэрхий хууль бус гэрээг тулган хүлээлгэсэн явууллагад автаж, нэгдүгээрт, тусгаар тогтнолоо хөрш зэргэлдээ хоёр улсаар зөвшөөрүүлэх, хоёрдугаарт, нутаг дэвсгэрийнхээ бүрэн бүтэн байдлыг хадгалах гэсэн зорилго нь гүйцэлдээгүй юм. Энэхүү нэгдүгээр зүйлээр, 1913 оны Орос-хятадын хууль бус гэрээг зөвшөөрүүлсэн нь 1915 оны Хиaгтын гэрээг хууль бус гэж тооцох нэг үндэслэл болно. Учир нь, уул гэрээний бусад заалт зөвхөн нэгдүгээр зүйлийг тодотгох, нарийвчлахад чиглэгдэж, 1913 оны тунхаг, ноотын санаанууд, зарчмуудыг давтжээ. Тухайлбал, хоёрдугаар зүйлээр, Богд хаант нэгдсэн Монгол Улс хятадын сюзеренитетийг арга буюу хүчинд автан зөвшөөрөн хүлээсэн байна.

Мөнхүү гэрээ бичгийн гуравдугаар зүйлд, автономит Гадаад Монголоос олон гадаад улс лугаа засаг ба газар дэлхийд холбогдох олон улсын хоорондох гэрээ бичиг байгуулах эрхгүй, аливаа Гадаад Монголын засгийн ба газар дэлхийд холбогдох хэрэг зүйлийг Думдад улсын засгийн Газраас Думдад, Орос хоёр улсаас солилцсон мэдтүгэй хэмээсэн хоёрдугаар зүйлийн ёсоор шийтгэхээр хүлээвэй гэжээ. Энэ зүйлд зааснаар Богд хаант нэгдсэн Монгол Улс задран сарниж, түүний Гадаад Монгол хэмээсэн тэр хэсэг нь олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах эрхээ хасуулж, хэрэв аль нэг улс оронтой гэрээ хэлэлцээр байгуулах аваас Хаант Орос, Хятадын хөрөнгөтний бүгд найрамдах улсаас зөвшөөрөл авахаар болсон нь Хиaгтын гэрээний хууль бус, тэгш бус чанаруудыг тодотгож байгаа юм.

1915 оны Хиaгтын гэрээ нь энэ мэт, талуудын хүлээсэн үүрэг эрс тэгш бус, монголчуудын хууль ёсны хүсэл зоригийг Орос, хятад хоёр улс хавчин боож, тусгаар тогтносон Богд хаант нэгдсэн Монгол Улсын бүрэн эрхийг зөрчиж, хязгаарласан санаа, заалтуудыг агуулж байна. Ийм ч учраас, 1915 оны Хиaгтын гэрээг хууль бус гэрээ хэмээн үзэх



бүрэн үндэстэй. Хиагтын гэрээгээр, Богд хаант нэгдсэн Монгол Улсыг задлан хуваасан Орос, хятадын бодлогыг баталгаажуулсан билээ. Академич Майский гэрээг байгуулах явцад хэлэлцээрийн үеэр Орос, хятадын төлөөлөгчдийн дунд гарсан нэг зөрчлийг тэмдэглэн үлдээсэн байдаг. Тэрбээр: “Хиагтад болсон хэлэлцээрийн үед хятадын төлөөлөгчид Автономит Монголын бүрэлдэхүүнд Урианхай хязгаарыг оруулах гэсэн боловч Оросын төлөөлөгчид үүнийг эсэргүүцжээ” хэмээн бичжээ. Хаант Орос нь эртнээс Урианхайн хязгаарыг монголчуудаас салгахыг эрмэлзэж байсан бөгөөд 1912, 1913, 1915 оны гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулахдаа энэ нутаг дэвсгэрийг монголчуудаас хүчирхийлэн авах боломжтой болсон байна. Түүнийг нь оросуудаас буцаан авах гэсэн Хятадын талын сонирхлыг 1915 оны гэрээг байгуулах хэлэлцээрийн явцад оросууд эсэргүүцсэн нь нэгэнт олсон олзоо алдахгүй гэсэн дээрэмчний сэтгэхүйтэй холбоотой юм. Ийнхүү Хиагтын гэрээгээр Хаант орос нь Урианхайн хязгаарыг, Хятадын хөрөнгөтний бүгд найрамдах улс нь Барга, Хөлөнбуйр, Или хязгаар, өвөрмонгол буюу Монголын урд хэсгийг Богд хаант нэгдсэн Монгол Улсаас хүчээр салган авсныг Монголын талд тулган зөвшөөрүүлж, Орос, Хятад хоёр дээрэмчин, түрэмгий бодлогоо далдлан хууль зүйлийн шинжтэй болгожээ.

Монголын гэрээнүүдийн тухай В.Л.Котвич нэлээн тодорхой бичсэнийг дэлгэрэнгүй эшлэхэд: “Монгол болон Хятадтай 1912, 1913 оны бидний /оросуудын/ байгуулсан хэлэлцээрийг харьцуулахад эхний гэрээнд нь “Монголын ард түмэн”, “Монголын” тухай эдгээр нэр томъёог ямар ч хязгаарлалтгүй заасан байхад саяхан хятадтай байгуулсан хэлэлцээр нь /1913 оны Орос-хятадын тунхаг, ноот/ Гадаад буюу Хойд Монголын автономитыг хангах асуудлыг хөндөж, ингэхдээ түүний бүрэлдэхүүнээс Барга, мөн 1913 оны зун, намар Халхын /Монголын/ отрядуудын чөлөөлсөн өвөр монголын тэр хэсгийг /Богд хаант нэгдсэн Монгол Улсын Засгийн газраас хятадын эзлэн түрэмгийлэгчдээс өвөрмонголыг чөлөөлөхөөр явуулсан дайны үр дүнд чөлөөлөгдсөн тэрхүү нутаг дэвсгэрийг хэлж байна-зохиогч/ хассан бололтой байна. Орос-хятадын хэлэлцээрийг монголчууд өөрсдөө хэдийгээр зөвшөөрөөгүй боловч гэрээгээр тогтоосон журам нь одоо болох гэж байгаа Орос, Хятад, Монголын төлөөлөгчдийн хэлэлцээрээр /1915 оны/ лав өөрчлөгдөхгүй нь магад бөгөөд энэ үеэс эхлэн Монгол нь улс төрийн хувьд Орос баталгаагаар хангаж буй Хойд Монгол болон Хятадын бүгд найрамдах улсын засгийн газраас хувь заяа нь шалтгаалах Урд монгол гэсэн хоёр болжээ” гэж бичсэн нь, уг гэрээнүүдээр Богд хаант нэгдсэн Монгол Улсыг задлан хуваасан Хаант орос болон Думдад иргэн улсын луйварчин, дээрэмчин харгис бодлогыг илчилсэн байна.

#### Товч дүгнэлт

Дээр бичсэн зүйлсэд тулгуурлан 1911 оноос 1919 оны хоорондох Монгол орны улс төрийн байдлын түүхийг сэргээн харахад:

**Нэгдүгээрт, Богд хаант нэгдсэн Монгол Улс байгуулагдсан нь түүхэн үнэн болно,**

**Хоёрдугаарт,** Тусгаар тогтносон Богд хаант нэгдсэн Монгол Улсын бүрэн эрх аажмаар хумигдаж, сэргэн мандсан Монголын төрт улс нь 1911 оноос нэг жил орчим тусгаар тогтнож байгаад 1912 оны гэрээгээр **АВТОНОМИТ МОНГОЛ УЛС**, 1913 оны **ТУНХАГААР**



**АВТОНОМИТ ГАДААД МОНГОЛ УЛС /Халх монгол, Ховдын хязгаарыг хамарсан улс/, 1915 оны гэрээгээр АВТОНОМИТ ГАДААД МОНГОЛ /Халх монгол, Ховдын хязгаар бүхий муж/ болж, олон улсын статус нь шат дараалан буурч, сүүлдээ улс гэсэн нэр ч үгүй болж, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал нь алдагдаж, задран, бусдын эрхшээлд эргэн орсон бага буурай орон болон хувирчээ. Өөрөөр хэлбэл, Манж чин улсын дарлалд байсан тэр үеийн байдлаасаа улам дордон доошилж, монголчуудын эсрэг атгаг санаа, хар хорын бодлогоор түүхийн маш урт хугацаанд зуунга хэрнээ хорлонтой харьцдаг хоёр их улстай хаяа хатган амьдрах хэцүү сонголтод хүрсэн юм.**

Монголын талаархи 1912, 1913, 1915 оны гэрээнүүдийн хууль зүйн талыг нягтлахад эдгээр гэрээнүүд нь дараах шинжийг агуулж байна:

Нэгдүгээрт, уг гэрээнүүд нь Богд хаант нэгдсэн Монгол Улсын болон монголчуудын хүсэл зориг, хууль ёсны шаардлагыг тусгаагүй байна. Монголчууд Манж Чин улсын ноёрхлыг түлхэн унагаж, тусгаар тогтносон улс болон байгуулагдаж, түүнийгээ хүлээн зөвшөөрүүлэх гэсэн боловч Монголын талаархи гэрээнүүдэд тэдний энэ бодлого, зорилго, хүсэл зориг тусгагдсангүй. Монголын талаархи гэрээнүүдэд монголчуудыг бүхэлд нь бус, зөвхөн түүний нэг хэсэг болох Халх зэрэг төв нутгаар амьдарч буй монголчуудын автономитыг тусгасан юм. Ингэснээр тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэх гэсэн Монголын талын хүсэл зориг тусгагдаагүй төдийгүй, харин ч Богд хаант нэгдсэн Монгол Улс олон улсын эрхийн статусын хувьд 1911 оноос үлэмж дордож, тусгаар тогтносон бүрэн эрхт улс байснаа, задран бутарч, нэг хэсгийг нь /Урианхайн хязгаар/ Орос, нэг хэсгийг нь /Өвөрмонгол, Или Тарвагатай болон Барга, Хөлөнбуйрын муж/ Хятад дээрэмдэн авч, зөвхөн Халх, Ховдын хязгаар бүхий нэг хэсгийг нь Орос, Хятадаас бүх зүйлээрээ хамааралтай Гадаад Монгол гэсэн нэрээр газар зүйн нэгэн муж төдий болгон хувиргасан билээ.

Хоёрдугаарт, Монголын талаархи гэрээнүүд нь тусгаар тогтносон монголчуудын зүй ёсны эрх ашгийг үгүйсгэж, Богд хаант нэгдсэн Монгол Улсын бүрэн эрхийг зөрчсөн гэрээнүүд мөн. Энэ чанар нь нэгд, Богд хаант нэгдсэн Монгол Улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож, түүний тусгаар тогтнолыг цуцалж, автономит нэр төдий муж нутаг болгосон, хоёрт, монголчуудын онцгой өмч болсон газар нутгийн асуудлыг хүчээр шийдвэрлэж, Богд хаант нэгдсэн Монгол Улсын нутаг дэвсгэрийг задалж, Орос, Хятад хоёр улс хувааж авсан, гуравт, Монголыг улс төрийн хувьд Орос, Хятадын хараат, худалдаа-санхүүгийн хувьд Оросын хараат болгосон зэрэг шинжүүдээр илэрч байгаа юм.

Гуравдугаарт, Монголын талаархи гэрээнүүд нь тулган хүлээлгэсэн гэрээнүүд мөн. Гэрээнүүдийг Монголын тал удаа дараа эсэргүүцэж, тэдгээрийг байгуулах явцад хэлэлцээр тасрах шахахад хүрч байсныг олон орны түүхчид, судлаачид, эрдэмтэн мэргэд тэмдэглэн бичиж үлдээсэн байдаг. Тулган хүлээлгэсэн гэрээ гэдгийг монголын тал ч тухайн үед мэдэж байсан байна. Тухайлбал, Богд хаант нэгдсэн Монгол Улсын Гадаадын хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамнаас Богд хаанд айлтгасан “Думдад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарласан дэвтэр”-г “...хүчирхэг нь буурайгаа дарлан элдэв эрх ашгийг булаан эзэрхэхийг хичээх нь олон улс нийтэд дадсан суртал мөн тул эс болгоомжилбоос үл болох...” хэмээн бичсэн нь Монголын тал асар их сэтгэхүйн дарамтанд байхдаа 1915 оны гэрээг аргагүйн эрхэнд зөвшөөрч баталсаныг харуулж байна.



Гэрээнүүдийн хууль зүйлийн асуудлыг өгүүлсэн бүгдээс үндэслэн дүгнэхэд, Монголын талаархи 1912, 1913, 1915 оны гэрээнүүд нь хууль бус, түүнийг байгуулснаас урган гарсан үр дагавар нь Орос, хятад, түүнчлэн Монголын тухайд хүчингүй юм. “Онолын хувьд олон улсын эрхийн үндсэн зарчмуудыг зөрчихөд чиглэсэн бүх гэрээ хэлэлцээрүүдийг хүн төрөлхтөн олон улсын гэрээ эрхийн үүднээс хүчингүй хэмээн үзэх ёстой. Энэ зарчим нь хэлэлцэгч талууд тэдний хоорондоо байгуулсан хэлэлцээр нь дурдсан шинжтэй байгааг хүлээн зөвшөөрөх сонирхолгүй байлаа ч гэсэн мөрдөгдөнө” гэж америкийн эрдэмтэн Ч.Хайд бичжээ. Олон улсын гэрээ эрхийн журмаар тэгш бус, хууль бус гэрээ хэлэлцээрийг үнэмлэхүй үл ялих хэмээдэг. Монголын талаархи 1912, 1913, 1915 оны гэрээнүүд бол бүр эхнээсээ үнэмлэхүй үл ялих гэрээнүүд байсан юм.

### Төгсгөлийн оронд

Богд хаант нэгдсэн Монгол Улсыг задлаж, устгахдаа Хаант Орос, Думдад иргэн улс хоёр нь монголчуудын талаархи, монгол үндэстний талаархи, монголчуудын газар нутгийн талаархи нэгдсэн бодол, нэгдмэл бодлого, өөрсдийн өнө мөнхийн эрх ашгийг боловсруулан уялдуулсан бөгөөд монголчуудын талаар тэдний зүгээс явуулж байгаа их гүрний, их үндэстэний дээрэнгүй бодлого, харгис, хорлонтой явууллагыг эсэргүүцсэн монголчуудын аливаа үйлдлийг сууриар нь монгол хүмүүн амьдарч байгаа бүхий л газар нутаг, орчинд хүчирхийлэн устгах, ийнхүү асуудал тавин тэмцэх монгол үндэстний бүх манлайлагчид, удирдагчдыг түүвэрлэн устгаж, болохгүй бол олноор нь хоморголон алж, хядаж, геноцид явуулж байсан, одоо ч далд байдлаар явуулсаар байгааг үгүй гэх газаргүй. /1/

1911 онд байгуулагдсан Богд хаант нэгдсэн Монгол Улсын манлайлагч, удирдагчид болох Наймдугаар Жибзундамба хутагт Богд Хаан, хатан зоригт чин ван Ханддорж, чин сүжигт сайд Да лам Цэрэнчимэд, жалханз хутагт Дамдинбазар, Ерөнхий сайд сайн ноён хан Намнансүрэн, чин зүтгэлт харчин гүн Хайсан, хатанбаатар Магсаржав, барга манлайбаатар Дамдинсүрэн ван, зоригтбаатар Тогтох тайж нарын олон арван хүнийг нэг нэгээр нь түүж устгаж байсан/2/ нь улмаар 1921 оноос Ардын хувьсгалыг удирдан манлайлагчдыг нэг нэгээр нь түүвэрлэн устгах /жишээлбэл, Д.Сүхбаатарын нас барсан хэрэг/, хэсэг бүлэг болгон хилс хэрэгт гүтгэж цаазалж устгах /жишээлбэл, 1922 оны 1-р сард Бодоогийн гэх арав гаруй хүнд холбогдох хэргийг зохиомлоор үүсгэж, 1922 оны 8-р сард Шар хадны энгэрт 14 хүнийг буудан алсан/ /3/ зэрэг хэлбэрээр хийгдэж байгаад 1937 оноос нийтийг хамарсан их хядлага, аллага болж /жишээлбэл, үндэс угсаагаар нь ялгаварлан устгах хэрэг, тухайлбал, буриад монголчуудын эсрэг чиглэсэн Лхүмбийн хэрэг, гарвал угсаагаар нь ялгаварлан устгах хэрэг, тухайлбал, Чингис хааны шууд удмын Алтан ургийн сурвалжит ноёд, ихэс дээдэс, эрдэмтэн мэргэдийг түүвэрлэн устгах хэрэг, монголоо гэсэн сэтгэл, үзэл бодлоор нь ялгаварлан устгах хэрэг, тухайлбал, нармай монголчуудын хэрэг буюу Гэндэн-Дэмидийн төв бүлэг ба “нармай монголын” хэрэг/4/, нийгмийн давхаргаар нь ялгаварлан устгах хэрэг, тухайлбал, лам нарын эсрэг явуулсан аллага, монголын сэхээтнүүдийн эсрэг явуулсан хэлмэгдүүлэлт, эрхэлж буй ажлаар нь ялгаварлан устгах хэрэг, тухайлбал, монголын ардын армийн удирдлага, офицерүүдийг устгах, хэлмэгдүүлэх хэрэг гэх мэт/, жинхэнэ геноцид шинжтэй болон газар авч, цааш цааш улам гүнзгийрч, арга хэлбэр нь нарийсаж, боловсронгуй болсоор өнөөдрийг хүрсэн бөгөөд энэ цаг дор Монголын оюун санааны манлайлагчид, улс төрийн удирдагчид, нийгмийн зүтгэлтнүүдийг шууд алах /жишээлбэл, Төмөр-Очирыг алсан хэрэг, Зоригийг алсан



хэрэг//5/ болон осол аваарт өртүүлж нас баруулах /Ш.Отгонбилэгийн хэрэг, Наранцацралтын хэрэг/, өвчин зовлонгоор өөд болгох /Дэмидийн хэрэг, Чойбалсангийн хэрэг, Цэдэнбалын хэрэг, Дашбалбарын хэрэг/, учир битүүлгээр амь насыг нь бүрэлгэх /Онмоогийн Энхсайханы хэрэг, Дангаасүрэнгийн хэрэг/, амьдралыг нь бусниулах, гэр бүлийг нь үймүүлэх, үр хүүхдийг нь өнчрүүлэх, гэр бүлтэй болголгүй, үр удам үлдээлгэхгүйгээр хавчин хяхаж, байгалийн зөн, амьдралын шаардлагыг нь гүйцэлдүүлэлгүйгээр боомилох /жишээлбэл, Монголын агуу их найрагч, Алтан ургийн сурвалжит тайж Дашдоржийн Нацагдоржийн хэрэг/ зэрэг олон янзын арга хэлбэрээр устгахаас гадна янз бүрийн гэмт хэрэгт зохиомлоор орооцолдуулж, зохион байгуулалттайгаар гэмт хэрэгтэн болгох, гэмт хэрэгтэн болгож харагдуулах /жишээлбэл, олон нийтэд мэдээлсэнээр Бат-Үүлийг Зоригийн хэргээр далимдуулан баривчилсан хэрэг, Тэмүүжин сайдыг хар тамхины хэрэгт холбогдуулах гэсэн хэрэг/, хууль бусаар эсвэл хуулийн заалтуудаар халхавчлан мөрдөж мөшгөх, айлган сүрдүүлэх, сүрэлэн дайрах, дарамтлах, гэр орон, эд хөрөнгө, өмч эд зүйлсийг нь рейдер, рекет, шантааж, зувчуулах зэрэг есөн шидийн аргаар дээрэмдэн авах /6/, тогтмол орлого, эх үүсвэрээр амьдрах боломжгүй болгохын тулд ажлаас нь халуулах, ямар нэгэн ажил эрхлэх, ажил хийх боломж олгохгүй байх /жишээлбэл, агуу их найрагч Ринчений Чойномын хэрэг/, энэ зорилгоор нэр хүндэд нь халдах /жишээлбэл, 1921 оноос ардын дайсан, хувьсгалын эсэргүү, эсэргүүний үлдэгдэл, эсэргүүний гэр бүл /7/, эсэргүүний зулбасга /8/, эсэргүүний хамсаатан /9/, зүүнтэн, баруунтан, японы тагнуул, ангийн дайсан, 1960-аад оноос намын дайсан, намын жанжин шугамыг гуйвуулагч, төр засгийг эсэргүүцэгч, нам, төрөөс урвагч, үндэсний үзэлтэн, улс төрийн гэмт хэрэгтэн, 1990-ээд оноос авлигачин, гэмт хэргийн загалмайлан эцэг, ордны цонхоор шээгч /10/, салаавч гаргагч, шанаа өгөгч, зууны луйварчин, сумтай хүн, галзуу, солиотой, мэдрэл муутай, шизотой, сэтгэцийн өвчтэй амьтан гэх зэргээр эрүүл хүний ой тоймд оромгүй доромж нэрээр нэрлэх, нийгэм дунд албаар тараах, сонин хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж цоллох, ард түмний дунд, ажлын газрын хамт олны дунд, ах дүү төрөл садан, анд нөхдийн дунд нэр хүндийг нь унагах зорилгоор ард түмний дунд бууны нохой гэж хочлогдох “мэргэжлийн” хүмүүсээр муулах, гүтгэлэг зохион байгуулах, тархи угаах ажиллагаа тогтмол хийлгүүлэх/, байнгын тасралтгүй өдөөн хатгалга явуулах, алхам тутамд нь янаглан хорлож, хэвийн амьдралаар амьдрах боломжгүй болгох, дунд нь хутган үймүүлж, хооронд нь хагаралдуулах /жишээлбэл, хууль зүйн сайд Тэмүүжинд хаяглан бичсэн сүрдүүлгийн захидлаас хэрхэн хүнийг байнга мөрдөж мөшгөх, янаглан хорлох, амьдралыг нь бусниулах гэх мэт аргуудын талаар тодорхой бичсэнийг уншиж мэдэж болно/, хууль хяналтын байгууллагаар /11/ дамжуулан гэсгээн цээрлүүлэх, залхаан тарчлаах, хилсээр ял эдлүүлэх зэргээр сэтгэл санааг нь үхүүлэх, бие бялдарыг нь өвчлүүлэх, эрүүл мэндийг нь муутгах, зориг бодлыг нь мохоох, үзэл бодлоос нь няцаалгах зэрэг амь, амьдралын хүнд нөхцөл байдалд зохион байгуулалттайгаар, санаатайгаар оруулж, монголчуудын эсрэг хядлага, геноцидийг маш олон янзын ил далд, нууц, нууцлагдмал зэрэг хувирсан хэлбэрээр нь явуулж байна. Энэ бол 1911 оны болон 1921 оны, мөн 1990 оны хувьсгалаас үүдэн гарсан бодит үнэн, хоёр их хөрш болох шовинист Орос, жанжлах үзэлтэй Хятадын зүгээс монголчуудын эсрэг нууцаар авч явуулж байгаа бодлого, явууллага, арга хэмжээний нэг томхон хэсэг юм. Тодруулж хэлбэл, Монголыг монголоор нь устгуулах, монгол хүнийг монгол хүнээр нь хэлмэгдүүлэх бодлого, явууллага, арга хэмжээ юм.

Төгс Төгөлдөршил Төрийн Бус Байгууллага



**Дугаарласаны зүүлт тайлбар:**

1/ Орос, Хятад хоёр нь 1913 онд байгуулсан Тунхаг болон Ноот бичгээр монголчуудын талаар, монгол үндэстэний талаар, монголчуудын төрт улсын талаар, монголчуудын газар нутгийн талаар хамтын бодлогоо тодорхойлсон бөгөөд үүнийгээ монголчуудын талаар Орос, Хятад хоёрын баримтлах үндсэн суурь зарчим хэмээн үзэж одоо ч мөрдсөөр байгаа бөгөөд олон улсын гэрээ эрхээр хууль бус энэхүү баримт бичгээр тогтоосон зарчмаа баримтлан монголчуудыг нэгтгэхгүй байх, монголчуудын газар нутгийг нэгтгэхгүй байх, Монголыг зөвхөн Халх болон Ховдын мужаар хязгаарлах, ийнхүү Монгол гэж нэрлэгдсэн тэр нутаг дэвсгэрийг нь дотор нь задлан хувааж, газрыг нь гадны /хятад/ хүмүүсийн эзэмшил, өмчлөлд тараан өгүүлэх, Орос, Хятадад хамааралтай гээд байгаа монголчуудын өнө эртнээс амьдран ирсэн, амьдарсаар байгаа бусад нутаг дэвсгэрийг нь монголчуудаас хамааралгүй болгохын тулд Орос, Хятад улсын дотоод засаг захиргааны байгуулалтаар задлан жижиглэн хувааж, уугуул оршин суугчид болох монголчуудыг уг орон нутагт нь цөөнхи үндэстэн болгож уусган устгах, тусгаарлах, зааглах, монголчуудын байгуулах аливаа төрт улсыг нийгэм-эдийн засгийн хувьд бэхэжсэн, цэрэг армийн хувьд хүчирхэгжсэн, хөгжиж цэцэглэсэн төрт улс байлгахгүй байх үндсэн бодлого, зорилгыг баримталж, энэхүү үндсэн бодлого, зорилгоо хэрэгжүүлэхдээ монгол үндэстнийг байнга дарамталж, дарангуйлж байх, хооронд нь хагалан бутаргах, үүний тулд урвагч монголчуудыг, эсвэл монголчуудын дунд амьдарч байгаа цагаачидыг ашиглан хагаралдуулах, монголчуудыг эрлийзжүүлэх, үүний тулд эмэгтэйчүүдийг нь эрчүүдээс нь салгах, эмэгтэйчүүдийг нь цагаачидын эхнэр болгож үр хүүхдүүдийг нь олноор гаргуулах, цагаачидын монгол эхнэрээс гарсан үр хүүхдийг монголчуудын эсрэг ашиглах, монгол үндэстэний оюун санааны манлайлагчид, улс төрийн удирдагчид, нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн мэргэдийг түүвэрлэн устгах, шаардлагатай гэж үзвэл монголчуудыг үй олноор нь хоморголон устгах, монгол үндэстний соёл иргэншлийг мөхөөх, хэдэн мянган жилээр нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдарсан аж байдлыг нь янз бүрээр өөнтөглөн шалтаглаж устгах, түүхийг нь гуйвуулах, түүх бичлэгийг нь завхруулах, түүхийн аливаа баримт бичиг нотлох баримтуудыг устгах, хэл аялга, ястанаар нь хооронд нь хагаралдуулж, дунд нь зөрчил үүсгэх, дүүжингийн зарчмыг ашиглан нэг хэсгийг нь Оросууд дэмжиж, нөгөө хэсгийг нь Хятадууд дэмжиж, хооронд нь турхирч, байнга сөргөлдүүлж, нийгэмд нь савлагаа үүсгэж, монголчуудыг үзэл суртал, нийгэм-улс төрийн хувьд нэгдмэл болгохгүй байх, мөнгө санхүү, ахуй-эдийн засгийг нь хөгжүүлэхгүйгээр Орос, Хятадаас байнга хараат, хамааралтай байлгах, монголчуудыг оюун санааны хувьд доройтуулах, ингэхдээ монгол хүнийг эдийн шуналтай, амиа хичээсэн үзэлтэй болгон төлөвшүүлэх, монгол үндэстэний өсөн үржихүйг хязгаарлаж, монгол үндэстэний оршихуйн суурь үндэс болсон гэр бүлийг нь задлах, ингэхийн тулд монголчуудын дунд ёс суртахууны хүмүүжил, ёс заншлыг нь гутаан, үнэгүйдүүлж, нийгмийн дунд эр эмгүй садарласан, тогтвортой гэр бүлгүй, цэгцэрсэн амьдралгүй болгох явдалыг дэлгэрүүлэх, хүйсээр нь хагаралдуулж, эр нь эмийгээ хайрлах, эм нь эрийгээ хүндлэх ёс суртахууныг устгаж, монгол гэр бүлийг байнгын зөрчилтэй байлгах, үр хүүхэд төрүүлэх хүсэл зоригийг эдийн засгаар боомилон мохоох, гэр бүл дэх хүүхэд төрүүлэх, хүмүүжүүлэх хэвийн нөхцөлийг бүрэлдүүлэхгүй байх талаар арга хэмжээ авах, бодлого хэрэгжүүлэх, монгол хүүхдүүд монгол хүн болон төлөвшиж хүмүүжих бүх нөхцөл бололцоог аль болох хаах, гадны суртал, хүмүүжилд хамруулах, ингэхдээ Орос, Хятад болон бусад сургалтад хар нялхаас нь хамруулж, сургах, тархийг нь Орос, Хятад болон бусад үзэл сурталаар угааж,



цэнэглэх, монголчуудын дунд шашны болон бөө, мухар сүсгийн, мөн харийн суртал ухуулга, мунхруулгыг хэвлэл, мэдээлэл болон бусад боломжит бүх сувгаар асар хүчтэй бөмбөгдөх маягаар явуулах, оюун санааны хувьд төөрөлдүүлэх, тэднээс бүрэн хамааралтай болгох, монголчуудын байгуулсан төрт улсад монголчуудын эрх ашгийг хамгаалах аливаа төрийн хүчний байгууллагыг бий болгуулах, байлгуулахгүй байх, цагдаа, хууль хяналтын байгууллагыг нь хяналтандаа авч, залж удирдах, монголчуудын эсрэг ашиглах, хууль хяналтын байгууллагаар нь дамжуулан монголоо гэсэн үзэлтэй хүмүүсийг нь тодруулж, дарамтлах, амьдралыг нь бусниулах, алж устгах, тэд нарыг хэлмэгдүүлэх ажлыг хууль хяналтын байгууллагаар нь гүйцэлдүүлэх зэрэг тоолж баршгүй, тоочиж гүйцэшгүй арга хэмжээнүүдийг тохиолдол бүрт нь тааруулан Орос, Хятад хоёр дипломат болон тагнуулын, бизнесийн, хууль хяналтын ажилтнуудын, сургалтын, мөн бусад сүлжээгээрээ ил, далд, урт, дунд, богино хугацааны аливаа боломжит бодлого, арга хэмжээгээр монголчуудын эсрэг хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдний зүгээс Монголд, монголчуудад тогтоосон хяналтаа алдахгүйн тулд юу ч хийхээс буцахгүй гэдэг нь Монголын түүхээр нотлогдсон зүйл, бодитой болсон түүхэн үйл явдал билээ. Тухайлбал, Зөвлөлт засгийн үед Оросууд буриад монголын олон сэхээтэн, оюун санааны манлайлагчид, эрдэмтэн мэргэд, лам нар, эгэл жирийн буриад хүмүүсийг /ойролцоогоор 20-30 мянган хүмүүс/ үй олноор нь хоморголон устгасан бөгөөд Дэлхийн 2-р дайны дундуур халимаг монголчуудыг нялх хүүхэд, эмгэд хөгшид, жирэмсэн эмэгтэйчүүд гэдгийг тоолгүйгээр өвлийн ид хүйтэнд нөмгөн нүцгэн шахуу гэр орноос нь дайчлан баривчилж, товарын вагонд бөөн бөөнөөр нь шахан ачиж, Сибир лүү нутаг заан цөлсөн тул замдаа нийт цөлөгдсөн хүмүүсийн бараг гуравны нэг шахуу нь өлсөж, осгож, хөлдөж үхсэн байдаг. Мөн цөлөгдөж очсон газраа өлсгөлөнд нэрвэгдэж нэлээд монголчууд үхсэн гэдэг. Ойролцоогоор 50-аас 100-д мянган халимаг монголчууд үхсэн гэсэн тойм тоо байдаг. Харин их үндэстний жанжлах үзлээр өвчилсөн коммунист Хятадад монголчуудыг үй олноор нь хоморголон алж, яргалж /жишээлэхэд, Хөх толбо сонинд бичсэнээр, жирэмсэн эмэгтэйг хөрөөдөж алсан байх гэх мэт, зарим нэг баримт мэдээг өвөрмонгол эмч Аюурзанын Өлзийбаярын бичсэн “Монголдоо тэмүүлсэн сэтгэл” номонд цухас дурдсан байдаг/, мөн өлсгөлөнд нэрвэгдүүлж, үхүүлсэн байдаг /Оросууд украинчуудыг 1930-д онд өлсгөлөнд нэрвэгдүүлэх замаар нэлээдгүй устгасан шиг/. Соёлын довтолгооны үеэр хунвэйбин буюу улаан хамгаалагчидын гарт маш олон монголчууд яргалуулж, алуулсан, нутаг заагдан, цөллөгт явж, эргэж нутагтаа ирж чадалгүйгээр нанхиадуудын дунд уусаж утсан байдаг. Нийтдээ нанхиадууд 1910-20-д оноос хойш Оростой нийлж Монголоос дээрэмдэж, салгаж авсан монголчуудын эртний нутаг дэвсгэрт амьдарч байсан монголчуудаас ойролцоогоор нэг саяас гурван саяыг нь устгасан гэсэн тойм тоо байдаг. Харин Орос болон Хятадуудын зүгээс Халх болон Ховдын хязгаараар нутаг дэвсгэрийг нь тогтоож, Монгол гэж тооцохоор тохирсон нутаг дэвсгэрт амьдарч буй монголчуудын хувьд Орос, Хятад хоёр геноцид, хэлмэгдүүлэлтийг ихээхэн ур ухаан зарж зохион байгуулсан байдаг бөгөөд монголчуудын өөрсдийнх нь байгуулсан төрийн нэг хэсэг болох хууль хяналтын байгууллагыг нь, эсвэл Онцгой бүрэн эрхт комисс, Тусгай комисс гэх мэт залхаан цээрлүүлэх нэгж байгуулан монголчуудын эсрэг ашиглаж, монголчуудыг монголчуудаар нь алж, устгуулах аргыг хэрэглэсэн байдаг. Ингэхдээ оросууд улс төрийн шийдвэр, чиглэлийг гаргаж, оросын чекистүүд гүйцэтгэлийг зохион байгуулж, монголын чекистууд, хууль хяналтынхан оросуудын шууд заавар, хяналтан дор хэлмэгдүүлэлт, аллагыг гардан хийж, харин Монголд амьдарч байгаа цагаач хятадууд монголчуудыг хутган үймүүлэх, тагнах, мөрдөх, оросуудад



болон өөрсдийн эх газар болох Хятад руугаа мэдээлэх ажлыг хариуцан хийж байсан байдаг. Их хэлмэгдүүлэлтэд Монголд амьдарч байсан цагаач хятадууд өртөөгүй байдаг нь улаан коммунист Орос, шар коммунист Хятад хоёрын хоорондын тохироо, хэлэлцээ байдагтай холбоотой бөгөөд 1921 онд Ардын хувьсгалаар Халхаас шахагдан зайлуулагдсан гамингуудыг оросууд аварч нутгаараа дамжуулан Хятад руу илгээж явуулж байсан тэр л бодлогын үргэлжлэл их хэлмэгдүүлэлтийн жилүүдэд БНМАУ-д хэрэгжиж, Орос, Хятад хоёр хамтран монголчуудын эсрэг хэлмэгдүүлэлт, геноцидийг явуулсаны нотолгоо болдог.

2/Авгаржин Жа.Баяржаргалын “Богд хаант Монгол улсын төрийн зүтгэлтэн, жанжин баатрууд” /Улаанбаатар, 2011 он/ хоёр боть ном

3/энэ талаар сурах бичиг, судалгааны ном бүтээлд, мөн нийтэд зориулсан нээлттэй мэдээлэлтэй маш олон сонин хэвлэлд нийтлэгдсэн, телевиз, интэрнэт гэх мэт мэдээллийн хэрэгсэлээр эфирт нээлттэй түгээсэн нэвтрүүлэг, сошиал сүлжээнд байршуулсан нээлттэй материалуудад анхаарал татахуйцаар баримт нотолгоотой бичигдэж, хэвлэгдсэн зүйлс олон байдаг. Үүнээс зүгээр л нэгийг жишээ болгоход, зохиолч, судлаач Ц.Доржготовын бичсэн “1921 оноос Монголд захиалгат аллага эхлүүлсэн Коминтерний еврей яргачин хэн байсан бэ?” гэх нэр дор Хориотой бүс сонин 2014 оны 12 дугаарт хэвлэгдсэн судалгааны өгүүлэл

4/Түүхийн шинжлэх ухааны магистр Гончигийн Ариунболдын бичсэн “Нармай монгол”-изм /”панмонголизм”/-ын хэрэгт хэлмэгдсэн монголчууд /1937-1941/” /Улаанбаатар, 2012 он/ ном, мөн түүхч С.Ичинноров гуайн бичсэн “Түүхийн үнэний мөрөөр” цуврал номнууд

5/Хэвлэл мэдээлэлд хэвлэгдэж, олон нийтэд зориулагдан нийтлэгдсэн нээлттэй мэдээлэл, баримтуудаас харахад Төмөр-очирыг алах хэргийг хойноос чиглэл өгч, Монголд ажиллаж байсан КГБ-ийн зөвлөхүүдээс хянан зохицуулж, монголчуудаас гүйцэтгэсэн байх магадлалтай байж болзошгүй гэж ойлгогдож байх. Харин Зоригийг алах хэргийг, хэрэв хэвлэл мэдээлэлд хэвлэгдэж, олон нийтэд зориулагдан нийтлэгдсэн, телевиз, радиогоор эфирт цацсан, интернэтээр сошиал сайтуудад байршуулан нийтэд нэвтрүүлсэн нээлттэй мэдээлэл, баримтууд нь үнэн байж болох магадлалтай гэж үзэн анализ, задлан шинжилгээ хийж үзэхэд, урдаас чиглэл өгч, хэрэв Зориг ерөнхий сайдаар ажиллавал эрх ашиг нь ноцтой хөндөгдөх, Монголд төрж өссөн, байнга амьдарч байгаа, тухайн үед Монголын хууль хяналтын байгууллагад ажиллаж байсан, эсвэл ажиллаж байгаад гарчихсан, Хятадаас хамааралтай 5-р цувааныханы эрх ашгийг хамгаалдаг тэр бүлэглэлээс зохион байгуулан, монголчуудаар гүйцэтгүүлсэн байх магадлалтай байж болзошгүй гэж ойлгогдож байх. Ялангуяа, Ганболдыг Ерөнхий сайдад зургаа-долоон удаа нэр дэвшүүлээд батлагдаагүй үйл ажиллагаа ийм шийдвэр гаргахад, эсвэл урьдчилаад бэлдсэн хувилбараар асуудлыг шийдэх нөхцөл байдалд хүргэсэн байж болох юм. Монголын төр Ерөнхий сайдаараа хэнийг томилохоо аль ч улс орон, хэнээр ч заалгахгүйгээр шийдэх бүрэн эрхтэй бөгөөд ийнхүү Ерөнхий сайдаа томилох асуудлыг аль нэг хэсэг бүлгийн эрх ашигт баригдалгүй шийдэж чадсанд эгдүүцэж хорсохдоо, Монголын төрийг басамжилж доромжлохдоо, монголчуудыг айлгаж дээрэлхэхдээ, эсвэл монголчуудад үгэнд орохгүй бол, бидний хүссэнээр байхгүй бол ингэдэг юм гэсэн сургамж өгөх маягаар шийдвэрлэсэн байж болох юм шиг харагдаж байна. Аль ч хувилбараар авч үзсэн энэ бол монголчуудын оюун санааны манлайлагчид, улс төрийн удирдагчид, нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн мэргэдийг нэг нэгээр нь түүвэрлэн түүж устгадаг геноцидийн тэр л хувилбар



хэрэгжсэн явдал юм. Зориг агсан бол үнэхээр монголчуудын оюун санааны манлайлагч байсан бөгөөд Ерөнхий сайдаар хэрэв томилогдон ажилласан бол Монголоо гэсэн бодол, сэтгэлтэй, Монголынхоо төлөө зохих шийдвэрийг гарган хэрэгжүүлэх зоригтой, ард түмэндээ нэр хүндтэй, биеэ даасан, чадварлаг улс төрийн удирдагч болох байсан. Чухам ийм байдал нь түүнийг Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллуулахгүй байхын төлөөх үндсэн шалтгаан болсон байх магадлалтай. Монгол Улсад Монголоо гэсэн бодолтой удирдагч байлгахгүй байхын төлөө, өөрсдийнх нь гарын дор байж, өнгөн дээрээ сайхан боловч үнэн чанартаа монголчуудын эсрэг чиглэсэн хэтийн үр дагавартай аливаа бодлого, шийдвэрийг хэрэгжүүлдэг тийм тоглоомын удирдагчийг Ерөнхий сайдаар тавиулах ашиг сонирхолын тулд энэхүү улс төрийн зохион байгуулалттай, захиалгат аллагыг гүйцэтгэсэн байх магадлалтай гэж үзэж болох байх гэж бодож байна.

6/өнөө цагийн хууль хяналтын байгууллагынханы зүгээс ард иргэдийн гэр орон, өмч хөрөнгө, эд зүйлийг хуулиар халхавчлан янз бүрийн аргаар дээрэмдэн авдаг зуршил 1920-1930-д оны их хэлмэгдүүлэлтийн үеэс уламжлагдан хадгалагдан дамжиж ирсэн бөгөөд их хэлмэгдүүлэлтийн үеийн хууль хяналтынхны дээрмийн талаар П.Цолмонгийн бичсэн “Түүхийн сэдэвтэй таван хүүрнэл” /Улаанбаатар хот, 2010 он/ ном, генерал А.Думбурайн бичсэн “Залхаан цээрлүүлэлт” /Улаанбаатар хот, 1997 он/ ном болон Улс төрийн талаар хэлмэгдэгсэдийн судалгааны төвөөс эрхлэн хэвлүүлсэн “Улс төрийн хэлмэгдэгсэдийн намтрын товчоон” гэх цуврал номнуудаас тодруулж уншина уу. Мөн хадгаламж зээлийн хоршооны хөрөнгийг хэрхэн зувчуулсан талаар сонин хэвлэлд нийтлэгдсэнийг уншина уу. Ер нь Элбэгдорж Ерөнхийлөгчийн хэлснээр хууль хяналтын байгууллагуудад хөрөнгөлөг хурандаа, дарга нарын давхарга нийгэмд бодитой буй болж, хууль хяналтын байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хяналтандаа авч, тодорхой бүлэглэлүүдийн ашиг сонирхлыг нийгэмд тулган хүлээлгэх нөхцөл байдлыг зохиомлоор бий болгож чадаж байсан нь нийгмийн амьдралын хэвийн явцад хүчтэй нөлөөлж, төрийн үр ашигтай удирдлагад саад учруулж байсан тул 1990-ээд оноос хойш хууль хяналтын байгууллагад бүрэн хийгдээгүй шинэтгэлийг гүйцэтгэх нийгмийн захиалгыг төрүүлсэн юм. Чухам хууль хяналтын байгууллагуудад хөрөнгөлөг хурандаа, дарга нарын давхарга үүссэн нь тэдний хөрөнгө, санхүү-эдийн засгийн хүчин чадал хэрхэн бий болсон бэ гэдэг асуудлыг нийгмийн өмнө тавьсан юм.

7/ Орос, Хятадуудаас монголчуудын эсрэг авч явуулж байсан хэлмэгдүүлэлт, геноцидэд монгол үндэстэний оюун санааны манлайлагчид, улс төрийн удирдагчид, нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн мэргэд, цэргийн дарга нар болон бусад хүмүүс өртөхөд тэднийг өөрсдийг нь баривчилж, тамлаж, яргалж, алж, устгахаас гадна тэдний гэр бүлийн хүмүүсийг хамтад нь хэлмэгдүүлж, амь, амьдралыг нь бусниулж, ажил албанаас нь халж, гэр орон, өмч хөрөнгө, эд зүйлсийг нь хураах нэрээр дээрэмдэж, гэр оронгүй, амьдрах эх үүсвэргүй болгон үгүйрүүлж, дахин сэхэл авах, хэвийн амьдралаар амьдрах боломжгүй болтол нь гэсгээн цээрлүүлдэг байсан байна. Ийнхүү хийгээгүй хэргийн төлөө хэн нэгэн монгол хүнд ял ногдуулаад зогсохгүй ар гэрт нь, гэр бүлийн хүмүүст нь, тэдэнд туслах гэсэн, тэдэнд ойртсон хавьтсан хүн бүрт ял халдааж, гэмт хэрэгтэн мэт хандаж, гэр бүлийн хүмүүсийг нь, эхнэр, үр хүүхдүүдийг нь давхар хэлмэгдүүлэн, амь, амьдралыг нь үгүй хийж байгаа нь монголчуудыг айлган сүрдүүлэх, хашраах гэсэн зорилготойгоос гадна монголчуудын эх орон, элгэн нутаг, үндэс угсааныхаа төлөө тэмцэх зоригийг мохоох, ийм үзэл бодлыг үе дамжуулан



уламжлуулахгүй байлгах, монголчуудын бие биенээ дэмжих дэмжлэгийг устгаж, хар амиа хичээсэн үзэл бодолтой болгон төлөвшүүлэх гэх мэт бодлоготой холбоотой юм. Эсэргүүний гэр бүл болсон эмэгтэйчүүдийг хэлмэгдүүлэгч нар элдвээр гоочилж, оролдож, хүчирхийлж, бэлгийн дур хүслээ хангадаг, эсвэл янз бүрээр дарамталж байгаад өөрийн эхнэрээ, нууц амрагаа болгон авдаг явдал гардаг байсан талаар зарим нэг мэдээ мэдээлэл байдаг. Тэр бүү хэл, эхнэрийг нь эзэмдэхийн тулд л нөхрийг нь хэлмэгдүүлж байсан гэх яриа хүртэл гарч, одоо хүртэл ам дамжин яригдсаар байна. Эмэгтэй хүнийг хэн ч биш гэж үзэж, дээрэлхэж доромжилдог, зэрлэг догшин харьцах, байгаа байдлаараа дарамтлан сэтгэл санааг нь үхүүлэх, байнгын хатуу хараа хяналтанд байлгах замаар эмэгтэйчүүдийн бие даасан байдал, эрх, эрх чөлөөг нь хазаарлах, боомилох, өөрийн эрхшээлд байлгах байдал хууль хяналтынханы дунд байдаг нь хэлмэгдүүлэлтийн үеэс тэдний дунд төлөвшсөн үзэгдэл юм. Хууль хяналтынхан өөрсдийнхөө дундаас гарсан иймэрхүү ноцтой хэргүүдийг нуун дарагдуулж, хаацайлан хамгаалдаг нь тэдний дунд эмэгтэйчүүдэд хандах энэхүү новшийн үзэгдэл нь амь бөхтэй оршин байх үндэс нь болдог. Жишээлбэл, саяхан, үр хүүхдүүдээ тамладаг, эхнэрээ хөнөөсөн гэх цагдаагийн хэрэг хэвлэл мэдээлэлээр цухасхан мэдээлэгдээд өнгөрсөн боловч асуудлыг хэрхсэн талаар ард иргэд, олон нийтээс тас нууж, хав даран өнгөрөөж байгаа бололтой. Эмэгтэй хүнийг өөрсдийн бэлгийн дур хүслийг хангах төдий амьтад мэтээр харьцах иймэрхүү сэтгэхүй нь монголын сайхан бүсгүйчүүдийг үзэн ядах, тэдэнд атаархан хорсох, тэднийг аль болох байнгын дарамтанд байлгах, болж өгвөл завхай явдалд татан орооцолдуулж, янхандуулах, өөрсдийн бузар муухай хэргээ үйлдэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой байдаг байна. Ер нь монголын сайхан бүсгүйчүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтийн сайтуудаар болон сошиал медиагаар элдвээр гоочлох, доромжлох, гутаах, амьдралаар нь тоглох үзэгдэл одоо ч гэсэн гарсаар байгаа бөгөөд үүнийг ард түмний дунд “бууны нохой” гэж хочлогддог нөхдүүд зохион байгуулалттайгаар хийдэг бөгөөд зорилго нь тэдгээр бүсгүйчүүдийг эрхэндээ байлгах, янз бүрийн буруу зөрүү зүйлд ашиглах, нууц амрагаа болгох зэргээр доош нь хийх гэж нэрлэгддэг тэрхүү үзэгдэлүүд монголчуудын амьдралд байсаар байна. Хачирхалтай нь, урд зүгийн цустай, хятадын эрлийз эмэгтэйчүүдийн талаар ингэж доромжилсон, гутаасан, элдвээр гоочилсон зүйлс үндсэндээ бараг хэвлэл мэдээлэлээр гардаггүй бөгөөд ихэнхидээ монголын сайхан бүсгүйчүүдийн талаар иймэрхүү бохир зүйл их тараагддаг. 1920-1930-аад онуудын их хэлмэгдүүлэлтээс үүдэлтэй, эмэгтэйчүүдийг бэлгийн дур хүсэл хангах төдий амьтад, орчин үеийн хэллэгээр бол секс боолчлолын объект мэтээр хандах ийм бохир үзэгдэл хууль хяналтынханаас хальж, өнөөдөр нийгэмд өргөн тархсан нь үнэхээр харамсалтай. Эхнэртэй, гэр бүлтэй мөртлөө эмэгтэйчүүдийг ажилд нь тусалсан нэрээр халхавч хийн, амьдралыг нь цусалж, бие сэтгэлийг нь бузарлаж, бэлгийн дур хүслээ гүйцэлдүүлсэн, салтаан дахь сахалтай төмсөгнөөсөө илүүгүй тархитай, садар явдалтай хуцан дарга нар энэхүү хэлмэгдүүлэлтийн аяныг албан байгууллага дахь бэлгийн дарамт, хүчирхийлэл маягаар уламжлуулан өрнүүлж байгаа нь монгол төрийн, дунд шатны дарга нарын ёс суртахууны ялзрал хууль хяналтынханахаас дутахааргүй байгааг харуулж байгаа нь үнэхээр эмгэнэлтэй. Эсэргүүний гэр бүл болсон эмэгтэйчүүдийг хэлмэгдүүлэх хоёрдахь хэлбэр нь баривчилж, хорьж байхдаа элдвээр тамлан зовоож, яргалах явдал юм. Энэ талаар нэгэн тохиолдлыг дурдахад, Долгоржав гэдэг буриад бүсгүйг жирэмсэн байхад нь баривчилж, тамласнаар хүүхэд нь зулбаж, хүүхдээ дутуу гаргасан байдаг бөгөөд уг эмэгтэй дутуу гарсан амьгүй хүүхдийнхээ цогцсыг хориход байх шээсний саванд хийж орхисон гунигт түүх байдаг. Эсэргүүний гэр бүл болох эмэгтэйчүүдийг хэлмэгдүүлэх гуравдахь хэлбэр бол баривчилж,



хорьж, яргалж, тамлаж байгаад буудаж цаазалж устгах явдал байсан юм. Тэр бүү хэл жирэмсэн байсан ч буудаж цаазалж байсан аймшигтай, гутамшигтай хэрэг явдал монголын хууль хяналтын байгууллагын бараан түүхэнд тодоос тодоор хараар тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Маршал Дэмидийн гэргий Навчаа, буриад бүсгүй Дунгаржид, Богд Хааны бага хатан Гэнэнпил зэрэг эмэгтэйчүүдийг жирэмсэн байхад нь буудаж цаазалсан, нэг сумаар хоёрын хоёр ямар ч гэм зэмгүй халуун амь тасалсан гунигтай, гутамшигтай явдал хэлмэгдүүлэгчдийг ямар хүн чанаргүй, эмэгтэй хүн, эх хүн, эхийн хэвлийд байх өчүүхэн нялх үрсийг хүртэл үл хайрлах харгис сэтгэхүйтэй аюултай яргачин, алуурчин байсныг нотолдог. Гэтэл монголчууд чинь бие давхар, тулгар эмэгтэйчүүдийг хайрлан энхрийлж, өмнүүр нь ойрхон гарахыг хүртэл цээрлэдэг сайхан ёс заншил, уламжлалтай ард түмэн шүү дээ. Маршал Дэмидийн гэргий Навчааг баривчлахын тулд хуурамч, зохиомол “Эсэргүү нарын гэр бүлийнхэний хэрэг” гэдгийг хүртэл зохиомжлон бичиж, түүнийгээ үндэслэн Дэнсмаа, Дулмаа нарын эмэгтэйчүүдийн хамт баривчилж, хэлмэгдүүлэлтийг гүйцэтгэсэн байдаг. Их хэлмэгдүүлэлтээс үүдэлтэй эмэгтэйчүүдийг доромжилсон иймэрхүү харьцаа нь ямагт эмэгтэй хүний өөрийнх нь хүсэл зоригоос үл хамаарах байх бөгөөд албадлагын шинжтэй, эсвэл эмэгтэй хүний амьдралын хүнд нөхцөл байдлыг далимдуулсан, тархийг нь угааж, мунхруулсан, хууран мэхэлсэн, залилсан, ямар нэгэн буруу зөрүү зүйлд ашигласан, ашиглахын тулд үйлдэгдсэн шинж чанартай байдаг.

8/эсэргүүний зулбасга гэдэг нь улс төрийн зохиомол хэргээр баригдаж, хэлмэгдсэн, эсвэл геноцид аллагад өртөж цаазлуулсан монгол хүний хүүхдүүдийг тухайн үед ингэж нэрлэдэг байсан. Эцэгээ алдаж өнчирсөн, зарим тохиолдолд эхээ мөн баривчлуулж, бүтэн өнчирч, амьдын хагацал үзсэн монголын мянга мянга өнчин хүүхдүүд үүрдийн сэтгэлийн шарх, хэзээ ч арилшгүй бараан дурсамжтайгаар амьдралаа гундуухан өнгөрөөснөө өнөөдөр дурсаж, Улаанбаатарын төв талбай дээр суулт хүрэтэл зохион байгуулж байгаа нь үнэхээр хэцүү. Энэ бол монгол үндэстэнд тохиолдсон асар том гай зовлонгийн нэгээхэн, тэгэхдээ үр дагавараар зүйрлэшгүй их хохирлын илэрч буй хэлбэр юм. Тэртээ 1920-30-д онуудад эсэргүүний хүүхэд болно гэдэг амьдаараа булшлуулна гэсэн үг байсан бөгөөд нялх балчир хүүхдүүдийн хувьд ялын тогтоол лугаа адил утгатай байсан. Эсэргүүний хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгт оруулахгүй, арай томрохоор нь ажил, албан байгууллагад авахгүй, амьдрах боломжоор нь үргэлж мөнхийн хяхан хавчиж, давхар давхар хэлмэгдүүлдэг байсан. Тухайн үед эсэргүүний хүүхдүүдийн талаар монголчууд ямархуу бодолтой байсныг нэгэн тохиолдолоор илэрхийлэн, Думбурай генералын “Залхаан цээрлүүлэлт” гэсэн номонд бичсэнийг эшлэхэд: “...3-р онц бүгд хурал дээр “халуун усны” Лувсан гэгч хүн “эсэргүү нарын өлгийтэй хүүхэд, өлөгчин нохойг хүртэл албал таарна” гэж” хэлсэн байдаг. Өлгийтэй хүүхдийг хүртэл албал таарна гэж хэлж байгаа нь зургаан зүйл хамаг амьтны тусын тулд гээд хүн бүү хэл хорхой шавьжийг хүртэл хороохоос цээрлэдэг уламжлалтай монголчууд гадны суртал ухуулга, тархи угаалтанд хэт их автаж, маш богино хугацаанд ямар их харгислал, ямар их хорсол зэвүүцэлтэй болон хувьсан өөрчлөгдөж, өөрсдөө түүнээсээ ямар их айсан аймхай хүмүүс болон хувирсаныг харуулж байгаа юм. Тэр бүү хэл, улс төрийн зорилгоор хүүхдүүдэд эрүүгийн хэрэг хүртэл үүсгэж байсан байдаг. Тухайлбал, 1930 онд Богд хааны хойт дүрээр тодорсон Сэлэнгэ аймгийн Цэнджавын хүү Лувсандоржийн хэрэг, 1944 онд Хүүхэн хутагтын хойт дүрээр тодорсон Хэнтийн мэргэн жаал Ламаадангийн хэрэг гэх мэт.



9/ хэлмэгдүүлэлтийн жилүүдэд хэлмэгдсэн хүмүүсийн ар гэрийг залхаан цээрлүүлэх зорилгоор гэр бүлийн хүмүүсийг нь зориуд ядуу гуйлгачин амьдралын хүнд нөхцөлд байлгаж, бүх эд хөрөнгийн хураах нэрээр дээрэмдэн авч, тэдэнд тусалсан монгол хүмүүсийг эсэргүүний хамсаатан гэж үзэж, баривчлан хорьж, яргалан тамлаж, хэлмэгдүүлдэг байсан нь нэгд, монгол хүн монгол хүндээ туслах халуун, дулаан, ах дүүсэг сайхан сэтгэл, уламжлалыг нь үгүй хийх зорилгоор, хоёрт, хэлмэгдүүлэлтэд өртсөн хүн болон түүний гэр бүлийнхнийг бусад хүмүүсээс тусгаарлах, ганцаардуулах, хууль хяналтын байгууллагын зүгээс байнга дарамтлах, хараа хяналтан дор байлгаж дурын нөхцөл байдал тулгах, гуравт, ямар ч гэмт хэрэг хийгээгүй, мөрөөрөө байгаа хүнийг эсэргүүний хамсаатан гэж хэрэг тулган шоронд хорьж, хууль хяналтынхан өөрсдийн илрүүлсэн эсэргүүнийхээ тоог нэмэгдүүлэх гэсэн хийрхэлтэй холбоотой. Думбурай генералын бичсэн “Залхаан цээрлүүлэлт” номонд эсэргүүний хамсаатан болгож гэмгүй хүмүүсийг хэцүүдүүлж байсан талаар бичсэнээс эшлэхэд: эсэргүү Дашчиравын гэр бүлд тус болж, хашаандаа амьдруулж байсан Лувсанцэрэн гэдэг хүнийг ногоон малгайтай гурван хүн ирж байцааж байсан, Дашчиравын гэргий Норжмааг ажилд оруулах талаар ярилцсан буриад Пунцаг гэдэг хүнийг ярилцсан өдрийнх нь шөнө баривчилсан зэрэг тохиолдлуудыг тэмдэглэн бичиж үлдээсэн байна. Монголчууд хэлмэгдсэн нэгэндээ туслахаас айж, амь, амьдралд нь туслах нь бүү хэл хөөж тууж, зайлуулахын түүс болдог байсан байна. Золбингийн Шижээгийн хүү Элксийн дурсамжаас дурдахад: “эсэргүүгийн гэр бүл гээд хажуудаа буулгах айл, ажилд авах байгууллага олдохгүй тун хүнд байлаа” гэж дурссан байдаг. Ингэж л монгол хүн монгол хүнээсээ айж зугатдаг, жийрхдэг, туслахаас цааргалдаг, эрээ цээргүй, эвийлэх сэтгэлгүйгээр хөөж туудаг, зөвхөн өөрийн хар амиа хоохойлдог өөдгүй зан сурталыг 1920-30-д онуудын их хэлмэгдүүлэлтийн үеэс монголчуудын тархинд нь суулгаж, олон зуун жил уламжлагдан ирсэн талын нүүдэлчидийн харилцан бие биендээ тусалж, хамтран амьдрах уламжлал, хүн хүнээ хайрлан дээдлэх монгол хүмүүжлийг устгасан билээ. Ингэж эсэргүүний гэр бүл, үр хүүхдүүд, тэдэнд тусалсан хүмүүсийг давхар давхар хэлмэгдүүлэхдээ мэдээлэгч нарыг их ашигладаг байсан бөгөөд ийм мэдээлэгч нар нь нэг бол хувьсгалын хийрхэлтэй хүн, нэг бол, хоорондын өс хонзонгийн харьцаатай хүн, нэг бол, тодорхой шагнал урамшуулал горьдсон, хууль хяналтынханы ивээлд багтаж, өөрийгөө хамгаалуулах гэсэн бодолтой хүн, нэг бол, монголчуудыг мөрдөж, тагнаж байсан цагаач хятад хүн, тэдний үр хүүхдүүд байдаг байсан.

10/ Ардчиллын алтан хараацай, ардчилсан хувьсгалын эцэг гэгддэг С.Зоригийн ээдрээт, хэцүү, ганцаардуулсан амьдралын талаар түүний анхны нарийн бичгийн даргын ажлыг хийж явсан Ц.Оюунцэцэг гэх эмэгтэйн ярилцлага Ардчилал сонины 2014 оны нэгэн дугаарт хэвлэгдэн гарсанаас үзэхэд С.Зориг төрийн ордоны цонхоор шээж, морь хараагүй, харин Ардын эрх сониньон тодорхой хэсэг бүлэг хүний явууллагаар гүтгэлэгийн шинжтэй материал нийтэлж, сенсааци хөөцөлдсөн байсан байдаг. Оюунцэцэг Ардын эрх сониньон Балдорж гуайтай уулзаж, асуухад Балдорж гуай “Би мэдэхгүй ээ, мэдээллийн мөрөөр сурвалжилж бичсэн” гэж хариулсан байдаг. Өөрөөр хэлбэл, үйл явдалыг нүдээр хараагүй, харин хэн нэгний өгсөн мэдээлэл гэх зүйлийг үндэслэн хэн нэг сэтгүүлчийн бичсэн материалд Балдорж гуай итгэж, сонинд хэвлэх зөвшөөрөл өгсөн байдаг байна. Мэдээлэл үнэн үү, худлаа юу, гүтгэлэг үү, зохиомол зүйл үү гэдгийг тухайн үед нь Ардын эрх сониньон нягтлалгүйгээр шууд хэвлэсэн бололтой байдаг. Энэ цаг үе бол С.Зоригийг улс төрөөс шахан гаргах, зайлуулах, орон зайгийн булаан эзэлж авах гэсэн улс төрийн явууллага эхэлчихсэн цаг үе байсан бөгөөд тухайн худал



мэдээлэлтэй гүтгэлгийн шинж чанартай нийтлэл нь Ардын эрх сонины нэр хүндийг ашиглан С.Зоригийн нэр хүндийг гутаах гэсэн явууллага байсан гэж ойлгогдохоор ярилцлагыг Оюунцэцэг Ардчилал сониныхонд өгсөн байна. Ер нь Оюунцэцэгийн ярьснаас дүгнэхэд, С.Зоригийг ганцаардуулах, хавчин хяхах, нэр хүндийг нь гутаах, хүсэл зоригийг нь мохоох гэсэн явууллага удаан хугацааны туршид тасралтгүй явагдаж байсан байна гэж ойлгогдохоор байна. Оюунцэцэгийн ярианаас эшлэхэд:”МоАХ-ны хоёрдугаар их хурал 1992 онд болсон. Энэ үеэр түүнийг Ерөнхий зохицуулагчаас буулгах сонирхолтой хүн олширч эхэлсэн... Хоёрдугаар их хурлын өмнө түүнийг хавчаад, ганцаардуулж байгааг өөрөө мэдэрч, “Би больёо оо, надаас энэ албан тушаалаа ав, би заавал хийе гэх шаардлага алга” гэж билээ. Тэгээд л хоёрдугаар их хурлаар МоАХ-ы ерөнхий зохицуулагчаар Ц.Элбэгдоржийг томилсон юм” гэж үйл явдлыг нүдээр харж, үзсэн гэрчийн хувиар ярьсан байна.

11/20-р зуун бол монгол үндэстэний хувьд, монгол туургатан хүмүүсийн хувьд маш их эмгэнэлтэй үйл явдалаар дүүрэн зуун байсан. Монголчуудын Манж Чин улсын дарангуйлалд байсан 200 гаруй он жилүүд шувтарч, 1911 онд туурга тусгаар улсаа байгуулсан боловч үүнтэй зэрэгцэн монголчуудыг дарангуйлан устгах, хоморголон алж, хядах геноцид бодлогыг Орос, Хятад хоёр их улсаас системтэйгээр, тодорхой хугацааны туршид хэрэгжүүлж, монголчуудад хэзээ ч нөхөгдөшгүй хохирол учруулж, эгэл жирийн олон хүмүүст уй гашуу, зовлон зүдгүүрийг үүрүүлсэн билээ. Орос, Хятад хоёр улс нь монголчуудыг зөвхөн Халх болон Ховдын нутгаар хязгаарлан, монголчуудын амьдарч байсан бусад нутаг дэвсгэрийг хураан авч, өөртөө нэгтгэсэн бөгөөд үүнийгээ хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор, мөн монголчуудаас үүнийг нь эсэргүүцэх аливаа явдал гаргуулахгүйн тулд монголчуудын эсрэг өргөн хүрээтэй аллага, хядлага үйлдэж, геноцид бодлогыг хэрэгжүүлсэн байдаг. Халх болон Ховдын нутгаар хязгаарлагдсан нутаг дэвсгэр дээр монголчууд тусгаар улс болох БНМАУ-ыг байгуулсан боловч Оросоос тус улсад хэлмэгдүүлэлтийг мөн л өргөн цар хүрээтэйгээр идэвхитэй явуулсан бөгөөд энэхүү аймшигт яргалал, аллагадаа монголчуудын өөрсдийнх нь байгуулсан хууль хяналтын байгууллагыг нь монголчуудынх нь эсрэг залхаан цээрлүүлэх машин механизм болгон ашигласан байдаг. БНМАУ-ын хууль хяналтын байгууллага нь үнэн чанартаа коммунист Орос улсын бодлогыг монголчуудад тулган хүлээлгэх аппарат болон хувирсан байсан бөгөөд монголчуудын хүсэл зориг, монголын төр улсын шийдвэрээс үндсэндээ бараг үл хамаарах байгууллага болсон байсан болно. Ийм байдал 20-р зууны туршид шахуу БНМАУ-д үргэлжилсэн бөгөөд монголын төрийн хууль хяналтын байгууллагыг оросууд чиглүүлж, ажлын цар хүрээ, үндсэн зарчмыг тогтоож, олон тооны зөвлөхүүд, мөн Орост сургагдаж бэлтгэгдсэн монгол ажилтнуудаар дамжуулан монголын нийгмийг хянах, монголын төрийг хянах, монголын удирдагчдыг хянах, монголын эдийн засгийг хянах, монголчуудыг өөрсдийг нь хянах ажлыг хийж гүйцэтгэж байсан болно. Өнөөдөр ч гэсэн хэдийгээр БНМАУ нь Монгол Улс болон өөрчлөгдөж, нийгмийн байгуулал социалист тогтолцооноос ардчилсан тогтолцоонд шилжсэн боловч хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа оросуудын тогтоосон тэр л голдрилоор явж, Монголын Засгийн газраас бараг үл хамаарах байдалтай, улс доторхи улсын шинжтэй байна. Өнөөдөр Монголын хууль хяналтын байгууллага нь хуулиар халхавчлан хуулийн дагуу гэж харагдахуйцаар, улс төрийн нууцхан зорилгоор Хууль зүйн сайдаа эрүүгийн хэргээр шантаажилж, Ерөнхий сайдаа нээнтэглэж, хууль ёсоор байгуулагдсан Засгийн газрыг аядуу эсэргүүцсэн шинжтэй байдлаар ажиллаж, Хууль зүйн сайд, Ерөнхий сайдын томилсон томилгоо, хууль ёсны шийдвэрийг



хэрэгжүүлэхийн оронд өөрчлүүлэхээр далдхан дарамтыг хэрэгжүүлж, гаргасан шийдвэрийг нь өөрчлүүлж чадаж байна. **Өнөөдөр Монгол Улсын хууль хяналтын байгууллага нь Үндсэн хуулиар тогтоосон засаглал хуваарилах зарчимаар байгуулсан хууль ёсны эрх мэдэл бүхий төрийн дээд байгууллагуудаас гадна, тэднээс засаглал, эрх мэдэл булаацалдсан, далд, хууль бус засаглалыг хэрэгжүүлсэн, удирдлагынхаа дээд болон дунд түвшиндээ өөрийн улс төрийн ашиг сонирхол бүхий, төрийн доторхи, ангид тусгай хэсэг болон агуулга нь хувирсан улс төрийн шахуу аппарат болсон байна.** Хууль бусаар эдэлж байгаа энэ их эрх дархыг нь эвдэж, ардчилсан нийгмийн шаардлага, хүчин төгөлдөр үйлчилж байгаа шинэ Үндсэн хуулинд нийцүүлсэн шинэчлэлтийг хууль хяналтын байгууллагын хүрээнд хийх гэсэн аливаа оролдлогыг хууль хяналтынхан ил, далд, элдэв хэлбэрээр, зохион байгуулалттайгаар эсэргүүцээр байна. Хууль хяналтынхан жирийн иргэнээс илүү эрх дарх эдэлж, иргэний нийгмийн дээр сандайлаад суучихсан, нийгмийг өөрсдийн хяналтан дор байлгаж, хүсэл зоригоо улс төрчдөд тулган хүлээлгэдэг, өөрт ашигтай дурын нөхцөл байдлыг хуулиар өөртөө бий болгуулж чаддаг байсан хуучин нөхцөл байдлыг нь өөрчлөх нь өнөөдрийн тулгамдсан зорилт болж байна. Тусгаар тогтносон, бүрэн эрхт Монгол Улсын Үндсэн хуулиар ард түмнээс хүчин төгөлдөр сонгуулиар сонгогдон байгуулагдсан Улсын Их Хурлаас сонгогдсон Ерөнхий сайдтай, томилогдсон сайдуудтай байгуулагдсан хууль ёсны Засгийн газартаа зайнаас захирагдах, захирагдахгүйн хооронд маягаар ажиллаж байгаа хууль хяналтын байгууллагыг, Ерөнхий сайд, Хууль зүйн сайдтайгаа хамтран нэг зорилго, нэгдмэл үр дүнд чиглэн ажиллах хүсэл эрмэлзэл төдий л байхгүй байгаа удирдлагатай хууль хяналтын байгууллагыг өнөөдрийн Монголын эмгэнэл гэлтэй билээ. Өнгөрсөн 20-р зуунд бид нар БНМАУ гэсэн улсад, нийгмийн социалист тогтолцоотой амьдарч байхад хууль хяналтын байгууллага нь нийгмийг бүхэлд нь хянах гэсэн оросуудын улс төрийн хүсэл зоригт нийцүүлэн монголчуудыг дарамталж, залж байсан бол өнөөдөр, 21-р зуунд бид нар Монгол гэх улсад, нийгмийн ардчилсан тогтолцоотой амьдарч байхад хууль хяналтын байгууллага нь иргэний нийгмийг дарангуйлах, Үндсэн хуулиар болон Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан хууль ёсны Ерөнхий сайдын институцийг аядуу эсэргүүцэх, хууль боловсруулах процесст шууд болон хөндлөнгөөс дам нөлөөлөх байдлаар оролцон өөрсдийн, эсвэл гадны захиалгат хүсэл зоригийг төрийн бодлого мэт батлуулан гаргуулж, урд зүгийн бодлогыг зөөлнөөр гулсуулан оруулж, хуульчлуулах, хуулийн албадлагаар монголчуудад сэм тулган хүлээлгэх, үүнийг ойлгож эсэргүүцэх хэнийг ч болов янз бүрийн хэрэгт орооцолдуулан, хууль хяналтын байгууллагаас мөрдөж мөшгих, хавчин хяхах, баривчилж хорих, хуулиар халхавчлан хэлмэгдүүлэх байдлыг зохион байгуулж чадаж байна. Саяхан гэхэд, Улсын прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэх хуулийн төслийг сонирхсон этгээдүүд нь Монголын хууль тогтоогчдоор дамжуулан Монгол Улсын Их Хурлаар батлуулж чадсан явдал юм. Энэ хууль өөрөө Үндсэн хууль зөрчсөн хууль бөгөөд Үндсэн хуулинд заасан засаглал хуваарилах зарчим, шүүх, шүүгчийн хараат бус байдлыг үгүйсгэсэн заалт, шинж, агуулгатай байгаагаараа зөрчилтэй хууль юм. Тэр бүү хэл, ардчилсан улс төрийн тогтолцоо бүхий иргэний нийгэмтэй Монгол улсад хууль хяналтын байгууллагынхан эрүүгийн хэрэг үүсгэхгүйгээр хүнийг тагнах, мөрдөх, гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхтэй байдаг төдийгүй түүнийгээ ч идэвхитэй ашигладаг байна. Прокурор, шүүгчийн ямар ч зөвшөөрөл, хяналтгүйгээр дураараа дургих нөхцөл байдлыг өнөөдөр хууль хяналтынхан өөрсөддөө бий болгоод эдэлж байна. Үүнээс гадна хувийн хамгаалалтын алба нэрийн дор хувь хүмүүс хувийн мөрдөх ажил нууцаар эрхлэн, хүмүүсийг мөрдөх, тагнах,



чагнах, гүйцэтгэх ажиллагаа явуулах зэргээр хүмүүсийн амьдралыг бусниулах ажиллагаа идэвхитэй явуулж байгаа бөгөөд үүний далд эзэд нь хууль хяналтын байгууллагад ажиллаж байсан, эсвэл ажиллаж байгаа, нөлөө бүхий удирдах түвшний хүмүүс байдаг. Ойрмогхон, Эдийн засгийн хөгжлийн яамнаас чагнах, дүрс бичлэг хийх төхөөрөмж илрүүлсэн нь чагнах, тагнах, мөрдөх ажиллагаа хэрээс хэтэрч, нийгэмд бие биенийгээ тагнах явдал эрүүл бус түвшинд хүрсэний нотолгоо болов. **Ардчилсан Монгол улсад хүнийг мөрдөх, чагнах, тагнах, гүйцэтгэх ажиллагаа явуулах эрх, мэдэл нь гагцхүү төрийн мэдэлд, төрийн монополь эрхэд хамаарах, зөвхөн хуулийн дагуу, хуулийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлэх онцгой эрх дарх мөн.** Энэ онцгой эрхэд халдсан, түүнийг үгүйсгэсэн, энэ онцгой эрх дархыг хувьдаа ашиглах гэсэн ямар ч түвшний ажилтан болов, ямар ч хүн байсан Монгол улсын бүрэн эрхэд халдаж, төрийн тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн, террорист ажиллагаа явуулсан гэж тооцогдож, хуулийн дагуу хариуцлага хүлээх учиртай. Хүн цөөтэй Монгол Улсад дурын хүн, тэр хүн нь жирийн иргэн, хууль хяналтын ажилтан, удирдах албан тушаалтан, Их Хурлын гишүүн, сайд, өмгөөлөгч хэн ч байсан хэн нэгнийг ямар нэгэн шалтагаар, тухайлбал, дургүйг нь хүргэсэн, хөрөнгө мөнгөтэй, гэмт хэрэг үйлдсэн байж магадгүй, эхнэр нөхөртэй маань явалдсан, үр хүүхдийг маань зодсон гэх мэтээр шалтаглан хууль бусаар, хуулиас гадуур, сайн дураараа эсвэл хэн нэгний захиалгаар, мөнгөний төлөө, өс хонзонгоор гэх мэтчилэн хүнийг мөрдөж мөшгөөд байвал ард иргэдийн амгалан тайван амьдрал алдагдаж, нийгэмд тогтворгүй байдал үүсэж, төрийн нууц, байгууллагын нууц, хувь хүний нууц гэсэн ойлголтууд устаж, хүний эрх, эрх чөлөө асуудал болж, хоорондоо бие биенийгээ мөрдөж мөшгөсөн, өсөрхсөн, харилцан тэмцэлдсэн, дайсагнасан нөхцөл байдал үүсэж, нийгэм, төр, улс оршин тогтноход хүндрэл бий болох билээ. Ийм ч учраас монголчууд бид өнөөдөр **монгол үндэстний эрх ашгийг хамгаалах, чухамхүү монгол үндэстний эрх ашгийг хамгаалдаг**, хэн нэг эрх мэдэлтэн, хэсэг бүлэг, гадны захиалгаар тэдний эрх ашигт нийцүүлсэн бодлогыг монголын төрийн бодлогод шургалуулан батлуулах явдалаас сэргийлж чадах, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай нэгжтэй болох шаардлагатай байна. Энэ нэгжийг өнөөгийн Тагнуулын байгууллагын суурин дээр байгуулж болох юм.



Төгс Төгөлдөршил Төрийн бус байгууллага

2014-06-25